

СУДАЛГААНЫ БАГ

Судалагаа, үнэлгээний ажлын ахлагч:

А.Нямдорж –Нийгмийн ухааны магистр

Судалгаа, үнэлгээний ажлын зохицуулагч:

А.Болортуяа –Бизнесийн удирдлагын магистр

Судалгаа, үнэлгээний ажлын багийн гишүүд:

М.Нэргүй

Д.Хишигжаргал

Н.Баясгаланчимэг

Э.Ариунжаргал

А.Ган-Эрдэнэ

Д.Анар

Бусад туслах судлаачид

Хаяг: *Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө 15/2, Элчингийн гудамж, Мидтаун оффис 504*

Утас: 7000 2444, 9910 1315, 9910 1827

Цахим шуудан: contact@hspim.com

Цахим хаяг: www.hspim.com

<https://www.facebook.com/hspim/>

https://twitter.com/HSPIM_MN

АГУУЛГА

| | |
|--|-----------|
| I БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ..... | 6 |
| Судалгаа үнэлгээний зорилго, зорилт | 6 |
| Судалгаа үнэлгээний хамрах хүрээ, ажлын үндсэн чиглэл..... | 6 |
| Судалгаа үнэлгээний мэдээлэл цуглуулах аргачлал | 6 |
| Судалгааны зохион байгуулалт..... | 8 |
| Мэдээлэл боловсруулах | 8 |
| II БҮЛЭГ. СУДАЛГАА ҮНЭЛГЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ | 9 |
| III БҮЛЭГ. 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨГСӨН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ | 12 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШУУРХАЙ, ИЛ ТОД БАЙДАЛ..... | 12 |
| АЮУЛ ОСОЛГҮЙ НАЙДВАРТАЙ БАЙДАЛ..... | 20 |
| ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛ..... | 26 |
| ҮНЭ, ТАРИФЫН ХЭМЖЭЭ | 28 |
| IV. БҮЛЭГ ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ 2017 ОНД ХИЙГДСЭН БОЛОН ХИЙГДЭЖ БАЙГАА БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ | 29 |
| V БҮЛЭГ. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО, СТРАТЕГИ, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ӨГСӨН ЭКСПЭРТТИЙН ҮНЭЛГЭЭ | 35 |
| ЗТХЯ-ны 2017 оны бодлого, стратегийн бичиг баримт хэрэгжилтэд салбарын мэргэшсэн ажилтан, мэргэжилтнүүдээс өгсөн ерөнхий үнэлгээ.. | 36 |
| ЗТХЯ болон тээврийн бусад салбаруудын үйл ажиллагааны 2017 оны ерөнхий үзүүлэлтүүдийг үнэлсэн байдал..... | 40 |
| ЗТХЯ-ны эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлсэн байдал..... | 41 |
| Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлсэн байдал..... | 42 |
| ДҮГНЭЛТ | 45 |
| ЗӨВЛӨМЖ | 48 |
| ХАВСРАЛТ | |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ЗТХЯ –Зам тээврийн хөгжлийн яам

ЭМНБХ –Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн ТББ

АТҮТТӨҮГ -“Авто тээврийн үндэсний төв” Төрийн өмчит үйлдвэрийн газар

ОНАТТ –Орон нутгийн авто тээврийн төв

ЗТХТ -Зам тээврийн хөгжлийн төв

УБТЗ ХНН –“Улаанбаатар төмөр зам” Хувь нийлүүлсэн нийгэмлэг

ИНЕГ –Иргэний нисэхийн Ерөнхий газар

УБ –Улаанбаатар

ТЗБО –Тээврийн зардлын буцаан олголт

ТХ –Тээврийн хэрэгсэл

АТХ –Авто тээврийн хэрэгсэл

АЖД –Албан журмын даатгалын үнэ

НТҮ –Нийтийн тээврийн үйлчилгээ

ХШҮДАГ –Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аупыитын газар

ЗТХС –Зам тээврийн хөгжлийн сайд

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| Хүснэгт №1 Судалгаа үнэлгээнд оролцогчдын хүн ам зүйн ерөнхий мэдээлэл | 9 |
| Хүснэгт №2 Орон нутгийн авто зам, тээврийн салбартай холбоотой мэдээлэл, галт тэрэг, нислэг, улс хот хоорондын тээврийн аялалын талаар мэдээлэл хаанаас авдаг эсэх | 12 |
| Хүснэгт №3 Аялалын талаарх ямар мэдээлэл авах хүсэлтэй байдаг талаар | 14 |
| Хүснэгт №4 Тасалбар хэрхэн авдаг талаар | 15 |
| Хүснэгт №5 Тээврийн хэрэгсэл хуваарьт цагтаа ирдэг эсэх | 15 |
| Хүснэгт №6 Тээврийн хэрэгсэл хуваарьт цагтаа хөдөлдөг эсэх | 16 |
| Хүснэгт №7 Тээврийн хэрэгсэл хуваарьт цагтаа очих газраа хүрдэг эсэх | 16 |
| Хүснэгт №8 Та билетийн суудлын дагуу сууж чаддаг эсэх | 17 |
| Хүснэгт № 9. Тээврийн хэрэгслийн өртөөнд хүрч буй эсвэл өртөөнөөс хөдөлж буй цагийн хуваарь нь дараагийн дамжин суух тээврийн хэрэгслийн үйлчилгээний хуваарь, Улсын хил ажиллах хуваарьтай нийцтэй эсэх /Төмөр зам/ | 17 |
| Хүснэгт 10 №. Тээврийн хэрэгслээр зорчихтой холбоотой болон зам тээвэртэй холбоотой таны гаргасан санал, гомдлыг тухайн байгууллага хүлээн эсэх | 18 |
| Хүснэгт № 11. Тээврийн салбарын байгууллагын үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг үнэлнэ үү | 19 |
| Хүснэгт № 12. ТХ-р аялах үед аюулгүй байдлын зааварчилгаа ил тод эсэх | 20 |
| Хүснэгт № 13 Тээврийн хэрэгслээр аялах үед байршуулсан аюулгүй байдлын зааварчилгаа ойлгомжтой байдаг эсэх | 21 |
| Хүснэгт № 14. Аюулгүй байдлын зааварчилгааг мөрддөг эсэх | 22 |
| Хүснэгт № 15. Тээврийн хэрэгслийн буудлын орчинд архи дан согтуурсан, танхай этгээдүүд байдаг эсэх | 22 |
| Хүснэгт №16. Тээврийн хэрэгслийн болон буудлын аюул осолгүй байдал | 23 |
| Хүснэгт №17. Үйлчилгээний ажилчид согтууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм тариа, ундаа хэрэглэсэн эсэх | 25 |
| Хүснэгт № 18. Тээврийн хэрэгслийн буудлын орчин, хүлээлгийн танхим болон гадна болон дотор орчны нөхцөл байдал | 26 |
| Хүснэгт №19 Үнэ тарифын үнэлгээ | 28 |
| Хүснэгт №20. Бүтээн байгуулалтын ажлуудын хэрэглэгчийн үнэлгээ | 29 |
| Хүснэгт №21. Зам, тээврийн салбарт хэрэгжүүлсэн бодлого, стратеги, тэдгээрийн хэрэгжилтийн нөхцөл байдалд өгсөн экспэртийн мэдээлэл | 35 |
| Хүснэгт №22 Бодлого, стратегийн бичиг баримтын хэрэгжилтэд экспертүүдийн өгсөн үнэлгээ | 36 |
| Хүснэгт №23. 2017 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ /Нийт 18 эксперт оролцсон ба мэдэхгүй гэсэн хариултыг үнэлгээнд оруулж тооцоогүй болно. / | 40 |
| Хүснэгт №24. Эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлсэн байдал. /Нийт 18 эксперт оролцсон ба мэдэхгүй гэсэн хариултыг үнэлгээнд оруулж тооцоогүй болно. / | 41 |
| Хүснэгт 25. МУЗГ-н 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ: /Нийт 18 эксперт оролцсон ба мэдэхгүй гэсэн хариултыг үнэлгээнд оруулж тооцоогүй болно. / | 42 |

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|----|
| График №1 Хэрэглэгчийн судалгаанд оролцогчдын нас, хүйсийн харьцаа..... | 10 |
| График №2 Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, үйлчлүүлж буй тээврийн хэрэгслийн төрөл | 10 |
| График №3 Тээврийн салбар, ТХ-н аялалын талаарх мэдээллийг хаанаас авдаг эсэх..... | 13 |
| График №4 Аялалын талаарх ямар мэдээлэл авах хүсэлтэй байдаг талаар..... | 14 |
| График №5 Тасалбар хэрхэн авдаг талаар..... | 15 |
| График № 6. ТХ-р аялах үед аюулгүй байдлын зааварчилгаа ил тод эсэх | 20 |
| График №7 Тээврийн хэрэгслээр аялах үед байршуулсан аюулгүй байдлын зааварчилгаа ойлгомжтой байдаг эсэх..... | 21 |
| График №8. Аюулгүй байдлын зааварчилгааг мөрддөг эсэх | 22 |
| График №9. Тээврийн хэрэгслийн буудлын орчинд архидан согтуурсан, танхай этгээдүүд байдаг эсэх..... | 23 |
| График №10 Үйлчилгээний ажилчид согтууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм тариа, ундаа хэрэглэсэн эсэх | 25 |
| График №11. Судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн салбартаа ажилласан жил, харьяалагдах тээврийн салбар | 35 |
| График №12. Судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн /Эксперт/ зэрэг цол, мэргэжил | 36 |

I БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧЛАЛ

Судалгаа үнэлгээний зорилго, зорилт

Зам, тээврийн хөгжлийн яамнаас салбар байгууллагуудаар дамжуулан 2017 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хөндлөнгийн хэрэглэгчийн үнэлгээ хийж, иргэд, үйлчлүүлэгчдэд үзүүлж байгаа ажил үйлчилгээний хүртээмж, чанар, албан хаагчдын ёс зүйн байдалд иргэдээс өгч буй үнэлэлт, дүгнэлт, сэтгэл ханамжийг тодорхойлж цаашид ажил үйлчилгээг сайжруулахад санал, зөвлөмж гаргахад оршино.

Судалгаа үнэлгээний хамрах хүрээ, ажлын үндсэн чиглэл

1. Улаанбаатар хот, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудийн авто тээвэр, авто зам, төмөр зам, агаарын тээврийн салбаруудын хэрэглэгчдэд хүрч буй үйл ажиллагааны шуурхай байдал, үйлчилгээний соёл, үнэ тарифын хэмжээ, аюул осолгүй найдвартай байдалд үнэлгээ хийх;
2. Зам, тээврийн салбарын бүтээн байгуулалтын ажлын чанар, гүйцэтгэл, эдийн засгийн үр өгөөжийн талаар судалгаа хийх;
3. Судалгааны ажлын явц, үр дүнг захиалагч талд танилцуулж, тайлагнаж, тайлан бэлтгэж өгөх;

Судалгаа үнэлгээний мэдээлэл цуглуулах аргачлал

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны түүврийн нэгж нь зам, тээврийн салбараар үйлчлүүлж буй болон үйлчлүүлсэн хэрэглэгч иргэн /хүн/ байх бөгөөд түүвэрт хамрагдсан иргэн тус бүрийг санамсаргүй түүврийн аргаар дараах шалгуураар сонгож мэдээллийг цуглуулсан болно. Үүнд:

1. Судалгаанд оролцогч нь 21-60 насны иргэн
2. Тухайн орон нутагт 3 сараас доошгүй хугацаанд түр болон байнга оршин суугаа Монгол улсын иргэн
3. Сүүлийн 6 сарын хугацаанд зам, тээврийн холбогдох салбар, тээврийн чиглэлээр үйлчлүүлсэн байх
4. Судалгаанд оролцогчийн гэр бүлийн аль нэг гишүүн нь салбарын байгууллага, аж ахуйн нэгжид ажилладаггүй байх

Улаанбаатар хот, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудийн авто тээвэр, авто зам, төмөр зам, агаарын тээврийн салбаруудын хэрэглэгч 874 иргэдээс, салбартаа 5-с дээш жил ажилласан туршлага, мэдлэгтэй 18 мэргэжилтнүүдээс судалгаа үнэлгээний мэдээллийг цуглуулж дүн шинжилгээг хийсэн болно.


Судалгааны мэдээлэл цуглуулахдаа

- ✚ Судалгааны асуумжын аргаар судалгаанд оролцогчдын ерөнхий байдлыг тодорхойлох 3 асуулт, тээврийн байгууллагуудын болон хэрэглэгчдийн хандлагыг тодорхойлох 7 асуулт, Иргэдийн онооны аргыг ашиглан салбарын ил тод, шуурхай байдлыг үнэлэх 19, Аюул, осолгүй найдвартай байдлыг үнэлэх 29 асуулт, Үйлчилгээний соёлыг үнэлэх 26 асуулт, Үнэ тарифыг үнэлэх 9 асуулт, 2017 оны

бүтээн байгуулалтыг үнэлэх 12 асуултаар нийт 95 үнэлгээний асуумж бөглүүлэн хэрэглэгчдээр үнэлгээ хийлгэсэн.

- Үнэлгээний асуумжыг Маш сайн /5/, Сайн /4/, Дунд /3/, Муу /2/, Мэдэхгүй /0/ гэсэн 5 шкалаар бүлэглэн оруулж өгсөн.

Зураг № 1 Судалгааны түүврийн бүтэц



Аргачлал 1: Асуумжийн аргаар хэрэглэгчдээс мэдээлэл цуглуулсан түүврийн хэмжээ:

| № | Тээврийн салбар | Хамрагдсан иргэдийн тоо |
|-------------|--------------------------------------|-------------------------|
| 1 | Агаарын тээвэр /зорчигчид/ | 302 |
| 2 | Улс хот хоорондын тээвэр /зорчигчид/ | 248 |
| 3 | Төмөр зам /зорчигчид/ | 250 |
| 4 | Авто зам /жолооч/ | 74 |
| 5 | Салбарын мэргэжилтэн /эксперт/ | 18 |
| Нийт | | 892 |

Аргачлал 2: Чанарын мэдээлэл цуглуулсан байдал:

- Хэрэглэгчид
- Хэрэгжүүлэгч агентлаг, орон нутгийн аж ахуй нэгж байгууллагууд
- Хамтран ажиллагч байгууллагууд (замын цагдаа, иргэний нисэхийн газар, Улаанбаатар төмөр зам, татвар гааль, бусад)

Аргачлал 3: Баримт бичгийн дүн шинжилгээ:

- Холбогдох байгууллагуудаас гаргаж буй статистик мэдээллүүдэд дүн шинжилгээ хийх (аваар осол, авто зам ашиглалтын татвар, ачаа тээвэр, гэх мэт)
- Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Зам, тээврийн хөгжлийн яамны бодлого, төлөвлөлт, стратегийн хэрэгжилт

Аргачлал 4: Ажиглалт дүн шинжилгээ:

Авто тээвэр, авто зам, төмөр зам, агаарын тээврийн салбаруудын онцгой талбаруудад тодорхой хугацаанд ажиглалтыг явуулж, үйлчилгээний ажилчдын соёл, зан

төлөв, үйлчлүүлэгчдийн хандлага, замын аюулгүй байдал гэх мэт бусад хүчин зүйлсүүдэд дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны зохион байгуулалт

Судалгааны багийн гишүүд ажлын төлөвлөгөөний дагуу санамсаргүй түүврээр Улаанбаатар хот, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудруу галт тэргээр, улс хот хоорондын тээврээр тус тус зорчин авто вокзал дээрх иргэд, жолооч, зорчигчдоос, Чингис хаан олон улсын нисэх буудлаар үйлчлүүлж буй иргэдээс Зам, тээврийн хөгжлийн яамны болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх хэрэглэгчийн үнэлгээг тодорхойлох судалгааны асуулгаар мэдээллийг цуглуулан холбогдох газруудын албан хаагчдаас тодруулга болон чанарын мэдээллүүдийг авч ажилласан.

Мэдээллийг цуглуулахдаа зарим холбогдох газруудад албан хүсэлтийг албан бичгээр уламжилж судалгаа үнэлгээний мэдээллүүдийг цуглуулсан. Үүнд: (Дорноговь аймаг, Замын-Үүд сумын гааль, Улаанбаатар Төмөр зам, Чингис хаан олон улсын нисэх буудлын аюулгүй байдлын алба болон маркетингийн хэлтэс гэх мэт). Улс хот хоорондын автобусаар зорчиж буй иргэд болон жолооч нараас судалгааны багийнхан аялалын явцад нээлттэй ярилцаж тоон мэдээллийг бататган чанарын мэдээллүүдийг цуглуулсан болно. Мөн орон нутгийн авто тээврийн төвүүдийн удирдлага, мэргэжилтнүүдтэй уулзан гол тулгардаг бэрхшээл, бодлогын хэрэгжилтийн нөхцөл байдлуудыг тодруулан ажилласан болно.

Мэдээлэл боловсруулах

Судалгаа үнэлгээний зорилго, мэдээлэл цуглуулахаар сонгосон аргуудтай уялдан мэдээлэл дэх шинж тэмдгийн утгуудыг тоон болон тоон бус шинжээр илэрхийлэгдэх байдлаар нь ангилан дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

Анкетын аргаар цуглуулсан тоон мэдээллийг судалгаа шинжилгээний SPSS програмд нэг бүрчлэн оруулж дүн шинжилгээг хийсэн. Түүнчлэн тоон бус утгаар илэрхийлэгдэх мэдээлэлд /баримт бичгийн судалгаа/ контент анализ, логик шинжилгээ хийх байдлаар чанарын боловсруулалт хийсэн. Орон нутгийн Зам, тээврийн хөгжлийн яамнаас салбар байгууллагуудын чанарын мэдээлэлийг Авто тээврийн үндэсний төв, Зам тээврийн хөгжлийн төвүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэнгүүдээс авсан нэмэлт мэдээллүүдтэй харьцуулан асуудлуудыг олон талаас нь харж тайланг боловсруулсан болно.

Судалгаа үнэлгээний мэдээлэл боловсруулах гол арга нь Иргэдийн онооны үнэлгээний аргаар авсан мэдээллүүдийг боловсруулсан ба нийт судалгаанд хамрагдсан иргэдийн МЭДЭХГҮЙ гэсэн хариулт сонгосон асуумжуудыг хасч, дахин засварлан доорх 4 үнэлгээгээр тооцоолон үр дүнг гаргалаа.

🚦 Маш сайн-5

🚦 Сайн-4

🚦 Дундаж-3

🚦 Муу-2

II БҮЛЭГ. СУДАЛГАА ҮНЭЛГЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ

Судалгаа үнэлгээг хийхдээ Улаанбаатар хот, Дорноговь аймаг, Дундговь аймаг, Өмнөговь аймгуудын тээврийн салбарын хэрэглэгчдээс санамсаргүй түүврийн аргаар иргэд, зорчигч, жолоочоос 874 хэрэглэгчээс асуумжийн аргаар судалгааг авсан бол салбарын мэргэшсэн ажилтан /Эксперт/ 18 хүнээс мэдээлэл авч нийт 892 хүн судалгаанд хамрагдсан болно.


Хүснэгт №1 Судалгаа үнэлгээнд оролцогчдын хүн ам зүйн ерөнхий мэдээлэл

| | | Давтамж | Хувь | |
|-------------|-----------------|---------------------------|------------|------|
| 1 | Хүйс | Эрэгтэй | 506 | 57,9 |
| | | Эмэгтэй | 368 | 42,1 |
| 2 | Нас | 21-30 | 296 | 33,9 |
| | | 31-40 | 293 | 33,5 |
| | | 41-50 | 164 | 18,8 |
| | | 51-60 | 121 | 13,8 |
| 3 | Боловсрол | Бага | 5 | 0,6 |
| | | Бүрэн бус дунд | 65 | 7,4 |
| | | Бүрэн дунд | 224 | 25,6 |
| | | Тусгай дунд | 76 | 8,7 |
| | | Дээд | 504 | 57,7 |
| 4 | Тээврийн салбар | Улс, хот хоорондын тээвэр | 248 | 28,4 |
| | | Төмөр зам | 250 | 28,6 |
| | | Агаарын тээвэр | 302 | 34,5 |
| | | Авто зам | 74 | 8,5 |
| Нийт | | 874 | 100 | |

Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгууд нь уул уурхай их хөгжсөн, хилийн боомт гарцтай, худалдаа наймаа, тээвэр, аялал жуулчлал ихтэй, суурин болоод явуулын хөдөлгөөнт хүн ам ихтэй онцлогтой аймгууд болно. Ялангуяа Өмнөговь аймагт ашигт малтмалын 80 гаруй ордтой үүнээс Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэс таван толгой, Энержи ресурс, Мөнх ноён суварга, Дун юань, Олон овоот гоулд, Зөв зүг, МАК, Чинхуа-Мак-Нарийн сухайт, Саус гоби сэндс, Өсөх зоос, Терра энержи, Жавхлант орд зэрэг 14 компаниуд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.


Судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 57,9 хувь нь эрэгтэй, 42,1 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийгэм, эдийн засгийн судалгаанд ихэвчлэн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү идэвхтэй, давамгай оролцдог ч Зам тээврийн хөгжлийн яамны хэрэглэгчийн судалгаанд эрэгтэйчүүд давамгай оролцож байгаа нь судалгааны мэдээлэл цуглуулсан аймгуудад уул уурхайн салбарт эрэгтэйчүүд түлхүү ажиллаж байгаа, тус аймгуудруу зорчиж буй тээврийн хэрэгслийн жолоочдын дийлэнх нь эрэгтэйчүүд, Худалдаа наймааны бараа таталт хийж буй зорчигчдын дийлэнх нь эрэгтэйчүүд байгаатай тус тус хамааралтай болно.

График №1 Хэрэглэгчийн судалгаанд оролцогчдын нас, хүйсийн харьцаа



Судалгаанд хамрагдсан иргэдийн 33,9 хувь нь 21-30 насныхан, 33,5 хувь нь 31-40 насныхан, 18,8 хувь нь 41-50 насныхан, 13,8 хувь нь 51-60 насныхан тус тус хамрагдсан байна. Дийлэнх буюу 67,4 хувь нь 21-40 насныхан эзэлж байгаа нь идэр насны залуучууд уурхайд ажиллах болон наймаа хийж байгааг харуулж байгаа юм. Түүнчлэн Монгол улс хүн амын насны бүтцийн хувьд залуу насныхан зонхилдог нь хөдөлмөрийн насны хүн ам өсч байгааг нотлон харуулж байна. Залуу идэр насныхан их байгаа нь ухаалаг утасны хэрэглээ өндөртэй, интернет байнга ашигладаг мэдээ мэдээллийг сайт, фэйсбүүк гэх мэт социал медиагаар шуурхай авдаг онцлогтой юм.

График №2 Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин, үйлчлүүлж буй тээврийн хэрэгслийн төрөл



Судалгаанд оролцогчдын 57,7 хувь нь дээд боловсролтой, 25,6 хувь нь бүрэн дунд боловсролтой, 8,7 хувь нь тусгай дунд боловсролтой, 7,4 хувь нь бүрэн бус дунд, 0,6 хувь нь бага боловсролтой иргэд хамрагдсан байна. Дийлэнх хувийг дээд боловсролтой иргэд эзэлж байгаа нь Монгол улсын хүн амын боловсролын түвшин өндөр байдагтай шууд

холбоотойгоос гадна судалгаанд хамрагдсан иргэд тухайн бүс нутгуудад үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн томоохон аж ахуй нэгжүүдэд ажилладаг иргэд байх магадлал өндөр юм учир нь судалгааны мэдээлэл цуглуулах цаг хугацааны үеэр УБ хотоос тухайн орон нутагруу, Орон нутгаас УБ хотруу зорчиж буй зорчигчид байгууллагын ажилчид нэлээдгүй олон байсан. Судалгаанд хамрагдсан иргэдийн боловсролын түвшин хэдий өндөр байх тусам мэдээлэл үнэн зөв өгөх, асуудлыг задлан дүн шинжилгээ хийх ур чадвар өндөр юм.

Судалгаа үнэлгээний мэдээллийг цуглуулахдаа Улс, хот хоорондын тээвэр буюу автобусаар зорчиж буй нийт 248 иргэнээс, Галт тэргээр үйлчлүүлж байгаа болон төмөр замын вокзалаар үйлчлүүлж буй 250 иргэнээс, Агаарын тээвэр буюу олон улсын нислэг болон орон нутгийн нислэгээр зорчиж буй 302 иргэнээс, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудруу авто зам ашиглан байнга зорчдог 74 жолоочоос тус тус мэдээллийг цуглуулж нэгтгэн боловсруулсан болно. Тухайн аймгуудруу зорчих авто зам сайжирсан өдөр бүр гэрээт Улс, хот хоорондын автобуснууд зорчдог ба үйл ажиллагаа менежмент нь тогтворжиж хэвшсэн. Өмнөговь аймагруу зуны цагт аялал жуулчлалтай холбоотойгоор иргэдэд үйлчлэх агаарын нислэг тавигддаг бол өвлийн цагт уул уурхайн компаниудын гэрээт нислэгүүд хийгдэж байна.

III БҮЛЭГ. 2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨГСӨН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШУУРХАЙ, ИЛ ТОД БАЙДАЛ

Хүснэгт №2 Орон нутгийн авто зам, тээврийн салбартай холбоотой мэдээлэл, галт тэрэг, нислэг, улс хот хоорондын тээврийн аялалын талаар мэдээлэл хаанаас авдаг эсэх

| | Авто зам /Жолооч/ | | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|--|-------------------|-------|----------------|-------|-----------|-------|---------------------------|-------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Утсаар | 8 | 10.8 | 150 | 49.7 | 38 | 15.2 | 53 | 21.4 |
| Веб сайт, Интернет | 13 | 17.6 | 124 | 41.1 | 51 | 20.4 | 71 | 28.6 |
| Гар утасны болон тусгай аппликэшн | 4 | 5.4 | 20 | 6.6 | 2 | 0.8 | 6 | 2.4 |
| Фэйсбүүк хуудас | 28 | 37.8 | 41 | 13.6 | 42 | 16.8 | 61 | 24.6 |
| Билетийн касс | | | 54 | 17.9 | 146 | 58.4 | 107 | 43.1 |
| Фм, Радио | 5 | 6.8 | - | - | - | - | - | - |
| Мэдээллийн самбар | 1 | 1.4 | 19 | 6.3 | 33 | 13.2 | 23 | 9.3 |
| Ухаалаг дэлгэц | 2 | 2.7 | 10 | 3.3 | 13 | 5.2 | 5 | 2.0 |
| Танилцуулах хуудас | 1 | 1.4 | 5 | 1.7 | 10 | 4.0 | 4 | 1.6 |
| Замын цагдаа | 3 | 4.1 | - | - | - | - | - | - |
| Шатахуун түгээгүүрийн ажилтан болон мэдээллийн ажилтан | 1 | 1.4 | 57 | 18.9 | 32 | 12.8 | 28 | 11.3 |
| Бусад | 9 | 12.2 | 10 | 3.3 | 16 | 6.4 | 15 | 6.0 |
| Нийт /давхардсан тоогоор/ | 88 | 118.9 | 490 | 162.3 | 383 | 153.2 | 373 | 150.4 |

Иргэд болон зорчигчид орон нутгийн авто зам, тээврийн салбартай холбоотой мэдээлэл, галт тэрэг, нислэг, улс хот хоорондын тээврийн аялалын талаарх мэдээллийг олон төрлийн арга хэлбэрээр авч байна. Ямар төрлийн мэдээлэл хайж байгаагаас хамаарч, мэдээллийн сувгийг сонгон ашиглаж байна. ЗТХЯ-ны мэдээ тайлан, үйл ажиллагаа, тээврийн салбартай холбоотой мэдээллийг сайт болон интернетээс түлхүү авдаг бол орон нутагт зорчих аялалын мэдээллийг утсаар шууд холбогдох болон тасалбар борлуулалтын цэгүүдээс авдаг байна. Төмөр замаар зорчигчдын 58.4 хувь нь, Улс, хот хоорондын тээврээр зорчигчдын 43.1 хувь тус тус билетийн кассаас билет худалдан авахдаа мэдээлэл авдаг бол агаарын тээврээр зорчигчдын 49.7 хувь нь утсаар, 41.1 хувь нь веб сайт, интернетээс мэдээлэл авдаг байхад орон нутаг, хот хооронд зорчдог жолооч нар 37.8 хувь нь фэйсбүүк хуудаснаас мэдээлэл авдаг онцлогтой байна.

График №3 Тээврийн салбар, ТХ-н аялалын талаарх мэдээллийг хаанаас авдаг эсэх



Зорчигчдын дийлэнх мэдээлэл авч буй хэлбэрийг дүгнэж үзвэл агаарын тээвэр, төмөр зам, автотээрийн үйлчлүүлэгч нарын хэвшил дадал болон иргэдийн соёлын ялгаатай байдал ажиглагдаж байна түүнчлэн тухайн салбар байгууллагуудын иргэдэд хүрч ажиллаж буй менежмент, маркетинг, үйлчилгээний цар хүрээг харуулж байна. Төмөр зам болон улс, хот хооронд зорчигчдын дийлэнх нь билетийн кассаар үйлчлүүлэхдээ мэдээлэл авч байгаа тул орон нутгийн болон нийслэлийн төмөр замын вокзал, авто вокзалуудыг сайн тохижуулж үйлчлүүлэгчийн ая тухтай байдлыг сайн хангах, мэдээлэл авах дэлгэц, самбар зэргийг сайн ажиллуулах, тэмдэг тэмдэглэгээ болон аюул осолгүй байдлыг сайжруулах, иргэдэд нээлттэй тэгш хүртээмжтэй хүрч ажиллах шуурхай түргэн үйлчилгээтэй байхаас гадна ажилчдын харилцааны соёл, ёс зүй, хувцаслалт зэргийг сайтар анхаарч ажиллах, ачаалал ихтэй цэгүүдэд иргэдэд үйлчлэх угтах үйлчилгээний ажилтанг ажиллуулан хэвшүүлэх шаардлагатай байна.

Иргэд хэрэгцээт мэдээллийг хамгийн амар хялбар, дөхөм арга хэлбэрээр авахыг хүсч байгаа ч юуг ашиглан, хаана хандан үйлчилгээ авахаа төдийлөн сайн мэдэхгүй байна. Иргэдийн мэдээлэл авдаг бусад эх сурвалж:


- ✚ Жолоочид –Авто тээврийн үндэсний төвөөс, нэг нэгнээсээ, жолооны курсээс, Телевизээс, тээврийн товчооноос гэж хариулт өгсөн байна.
- ✚ Агаарын тээврээр зорчигчид –Мессежээр болон судалгаанаас гэсэн бол
- ✚ Төмөр замаар зорчигчид –Гал тэргээр зорчиж байхдаа, гэр бүл найз нөхдөөсөө, бусад хүмүүсээс авдаг. Ерөнхийдөө мэдээлэл хомс байдаг.
- ✚ Улс, хот хоорондын тээврийн хэрэгслээр зорчигчид –Мэдээлэл сайн авдаггүй байна.

Хүснэгт №3 Аялалын талаарх ямар мэдээлэл авах хүсэлтэй байдаг талаар

| | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|-----------------------------------|----------------|-------|-----------|-------|---------------------------|-------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Цагийн хуваарь | 132 | 43.7 | 97 | 38.8 | 79 | 31.9 |
| Аялалын маршрут | 69 | 22.8 | 65 | 26 | 49 | 19.8 |
| Үнэ тариф | 155 | 51.3 | 94 | 37.6 | 67 | 27.0 |
| Тасалбар худалдаалах цэг, байршил | 34 | 11.3 | 62 | 24.8 | 56 | 22.6 |
| Хөнгөлөлт, урамшуулал | 117 | 38.7 | 89 | 35.6 | 85 | 34.3 |
| Заавар зөвлөмж | 42 | 13.9 | 26 | 10.4 | 33 | 13.3 |
| Бусад мэдээлэл | 5 | 1.7 | 6 | 2.4 | 6 | 2.4 |
| Нийт /давхардсан тоогоор/ | 554 | 183.4 | 439 | 175.6 | 375 | 151.2 |

Иргэд аяллын цагийн хуваарь, билетийн үнэ тариф, хөнгөлөлт урамшууллын талаар мэдээлэл авах илүү хүсэлтэй байдаг байна. Дээрх хүснэгтэд иргэдийн хамгийн их мэдээлэл авах хүсэлтэй байгаа үзүүлэлтийн хувийг улаан өнгөөр хайрцаглан салбар салбараар нь харуулав. Түүнчлэн иргэд бусад гэсэн сонголтод агаарын тээврээр болон автобусаар үйлчлүүлэгчид цаг агаарын нөхцөлөөс хамааран хойшлогдох байдал, тасалбарын хямдралын талаар мэдээлэл авах сонирхолтой байдаг байна. Иргэдийн авахыг хүсч буй мэдээллүүдийг ил тод мэдээллийн хэрэгслүүдэд байршуулах, иргэдийн ухаалаг утсаар интернетийн хэрэглээ ихсэж байгаа тул тээврийн байгууллагууд фэйсбүүк хуудсыг сайн ажиллуулж зар мэдээллийг шуурхай шинэчлэн хөгжүүлэлт хийдэг байх шаардлагатай байна.

График №4 Аялалын талаарх ямар мэдээлэл авах хүсэлтэй байдаг талаар



Иргэд аялалын тасалбарын хөнгөлөлт урамшуулал, хямдралд ихээхэн сонирхолтой байгааг анхаарч тээврийн байгууллагууд маркетинг сурталчилгааг энэ асуудалтай уялдуулж явуулбал илүү үр дүнтэй байна. Ялангуяа улс, хот хоорондын тээврийн


автобуснууд зорчигч дүүргэлт хангалтгүй явдаг тэдний гол өрсөлдөгчид нь хулгайн тээврийнхэн байдаг тул тэднээс ялгарах стратегийг баримталж ажиллах нь чухал юм.

Хүснэгт №4 Тасалбар хэрхэн авдаг талаар

| | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|-------------------------------|----------------|------|-----------|------|---------------------------|------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Интернэтээр захиалах | 57 | 18.9 | 10 | 4 | 32 | 12.9 |
| Билетийн кассаас очиж авах | 161 | 53.3 | 229 | 91.6 | 194 | 78.2 |
| Хүргэлтээр авах | 4 | 1.3 | 3 | 1.2 | - | - |
| Утсаар захиалаад очихдоо авах | 36 | 11.9 | 4 | 1.6 | 16 | 6.5 |
| Бусад мэдээлэл | 44 | 14.6 | 4 | 1.6 | 6 | 2.4 |
| Нийт | 302 | 100 | 250 | 100 | 248 | 100 |

Аялалын тасалбар борлуулалтын шинэлэг онлайн захиалгын үйлчилгээ нэвтэрсэн ч иргэд билетийн кассаас очиж тасалбар авдаг хэлбэрийг илүүтэй сонгон үйлчлүүлсээр байна. Ялангуяа төмөр замаар зорчигчдын 91.6 хувь нь, Улс, хот хоорондын тээврээр зорчигчдын 78.2 хувь нь тус үйлчилгээг сонгон үйлчлүүлж байна. Төмөр замаар зорчигчд нь төмөр замын тасалбар борлуулах цэгүүд онлайн захиалга, борлуулалт хийдэггүй, зорчигч ихтэй байдаг болохоор тасалбараа зарагдсан гэж нуун дарагдуулдаг танил хүмүүстээ өгдөг, билет шаглах асуудал байдаг талаар шүүмжилсэн.

График №5 Тасалбар хэрхэн авдаг талаар



Бусад гэдэгт сонголтоор агаарын тээврээр үйлчлүүлэгчид нь таньдаг хүнээрээ дамжуулан тасалбар авах, нисэх дээр өөрийн биеэр ирж авах гэж хариулсан байна.

Хүснэгт №5 Тээврийн хэрэгсэл хуваарьт цагтаа ирдэг эсэх

| Хариулт | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|----------|----------------|------|-----------|------|---------------------------|------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Гийм | 198 | 65.6 | 203 | 81.2 | 200 | 80.6 |
| Мэдэхгүй | 73 | 24.2 | 30 | 12.0 | 26 | 10.5 |
| Үгүй | 31 | 10.3 | 17 | 6.8 | 22 | 8.9 |
| 5-10 мин | 10 | 3.3 | 12 | 4.8 | 5 | 2.0 |

| | | | | | | |
|---------------|---|-----|---|-----|---|-----|
| 11-20 мин | 9 | 3.0 | 3 | 1.2 | 7 | 2.8 |
| 21-30 мин | 7 | 2.3 | 9 | 3.6 | 5 | 2.0 |
| 31-с дээш мин | 5 | 1.7 | 7 | 2.8 | 3 | 1.2 |

Тээврийн хэрэгсэл хуваарьт цагтаа ирдэг үү? гэсэн асуултад агаарын тээврээр зорчигчдын 65.6 хувь нь, төмөр замаар зорчигчдын 81.2 хувь нь, Улс, хот хоорондын тээврээр зорчигчдын 80.6 хувь нь тус тус хуваарьт цагтаа ирдэг гэж хариулсан бол хоцорч ирдэг талаарх үзүүлэлтийн хувийн жин бага байна. Агаарын саатлаас үүдэлтэйгээр агаарын тээвэр бага зэрэг хоцрох цөөн тохиолдлууд байдаг байна.

Хүснэгт №6 Тээврийн хэрэгсэл хуваарьт цагтаа хөдөлдөг эсэх

| Хариулт | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|---------------|----------------|------|-----------|------|---------------------------|------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Гийм | 214 | 70.9 | 232 | 92.8 | 181 | 73.0 |
| Мэдэхгүй | 48 | 15.9 | 14 | 5.6 | 21 | 8.5 |
| Үгүй | 40 | 13.2 | 4 | 1.6 | 46 | 18.5 |
| 5-10 мин | 22 | 7.3 | 3 | 1.2 | 34 | 13.7 |
| 11-20 мин | 16 | 5.3 | 1 | 0.4 | 10 | 4.0 |
| 21-30 мин | 2 | 0.7 | | | 3 | 1.2 |
| 31-с дээш мин | 1 | 0.3 | | | 1 | 0.4 |

Тээврийн хэрэгсэл хуваарьт цагтаа хөдөлдөг үү? гэсэн асуултад агаарын тээврээр зорчигчдын 70.9 хувь нь, төмөр замаар зорчигчдын 92.8 хувь нь, Улс, хот хоорондын тээврээр зорчигчдын 73.0 хувь нь тус тус хуваарьт цагтаа хөдөлдөг гэж хариулсан байна. Агаарын тээвэр хоцорч хөдөлдөг гол шалтгаан нь салхины хурд байдаг бол Улс, хот хоорондын тээврийн хоцорч хөдөлдөг гол шалтгаан нь зорчигч дүүргэлтийн асуудал байдаг байна.

Хүснэгт №7 Тээврийн хэрэгсэл хуваарьт цагтаа очих газраа хүрдэг эсэх

| Ерөнхий хүчин зүйлс | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|---|----------------|-------|-----------|------|---------------------------|------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Гийм | 220 | 72.8 | 212 | 84.8 | 169 | 68.1 |
| Мэдэхгүй | 52 | 17.2 | 24 | 9.6 | 40 | 16.1 |
| Үгүй | 30 | 9.9 | 14 | 5.6 | 39 | 15.7 |
| • 5-10 мин | 17 | 5.6 | 10 | 4 | 10 | 4.0 |
| • 11-20 мин | 8 | 2.6 | 4 | 1.6 | 6 | 2.4 |
| • 21-30 мин | 2 | 0.7 | - | - | 10 | 4.0 |
| • 31-с дээш мин | 2 | 0.7 | - | - | 8 | 3.2 |
| Хоцролтын шалтгаан | | 0.0 | - | - | - | 0.0 |
| • Цаг агаар | 37 | 12.3 | 2 | 0.8 | 27 | 10.9 |
| • Хурд | 1 | 0.3 | 6 | 2.4 | 16 | 6.5 |
| • Техникийн саатал | 2 | 200.0 | 6 | 100 | 6 | 2.4 |
| • Зохион байгуулалт, замын арчилгаа тордолт | - | - | 2 | 0.8 | 11 | 4.4 |
| • Осол аваар | - | - | - | - | 1 | 0.4 |
| • Бусад | 14 | 4.6 | 2 | 0.8 | 8 | 3.2 |

Тээврийн хэрэгсэл хуваарьт цагтаа очих газраа хүрдэггүй шалтгааныг иргэд судалгааны бусад гэсэн хариултанд төмөр замаар зорчигчид нь зөрлөг хүлээх гэж хариулсан бол агаарын тээврээр үйлчлүүлэгчдийн дийлэнх нь нислэгийн зохион байгуулалтаас хүрэх газраа цагтаа хүрдэггүй гэж үзсэн бол зарим тохиолдолд өндөр албан тушаалтнуудтай хамт нисэхэд хуваарьт цагтаа нисээгүйгээс, хуваарьт цагтаа хүрдэггүй гэж хариулсан байна. Улс, хот хоорондын тээврийн зорчигчид хариулахдаа гэрлэн дохио удсанаас, зорчигчдоо хүлээснээс, олон удаагийн зогсолт хийснээс, цаг барьдаггүй учраас гэж хариулсан байна.

Хүснэгт №8 Та билетийн суудлын дагуу сууж чаддаг эсэх

| Хариулт | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|--------------------------------|----------------|------|-----------|------|---------------------------|------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Тийм | 280 | 92.7 | 204 | 81.6 | 224 | 90.3 |
| Үгүй | 10 | 3.3 | 26 | 10.4 | 11 | 4.4 |
| Заримдаа /Дотроос билет авдаг/ | 12 | 4.0 | 20 | 8 | 13 | 5.2 |
| Нийт | 302 | 100 | 250 | 100 | 248 | 100 |

Иргэд билетийн суудлын дагуу сууж чаддаг уу? гэсэн асуултад агаарын тээврийн зорчигчдын 92.7 хувь нь Төмөр замын зорчигчдын 81.6 хувь нь, Улс, хот хоорондын тээврийн зорчигчдын 90.3 хувь тийм гэж хариулсан байна. Галт тэрэг болон автобусны замын явцад жижиг өртөө буудлуудаас заримдаа билетгүй зорчигч суудаг. Эдгээр зорчигч нь суудлын номер харгалзахгүй аль боломжтой хэсэгт сууж зорчдог. Авто вокзалаас цагийн хуваарийн дагуу цагтаа хөдөлж автобусанд амжиж суух гэж зорчигч билетийн кассаас билет авч амжилгүй шууд сууж байгаа тохиолдлууд судалгаа үнэлгээний явцад нэлээдгүй ажиглагдсан. Улс, хот хоорондын тээвэрт хувийн жижиг тэрэг их явдаг тул автобусаар зорчиж буй иргэд хангалтай дүүрдэггүй тул билетгүй зорчигч суудалгүй явна гэж бараг байдаггүй болно.

Хүснэгт № 9. Тээврийн хэрэгслийн өртөөнд хүрч буй эсвэл өртөөнөөс хөдөлж буй цагийн хуваарь нь дараагийн дамжин суух тээврийн хэрэгслийн үйлчилгээний хуваарь, Улсын хил ажиллах хуваарьтай нийцтэй эсэх /Төмөр зам/

| Хариулт | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|---------------|----------------|------|-----------|------|---------------------------|------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Тийм | - | - | 161 | 64.4 | - | - |
| Мэдэхгүй | - | - | 79 | 31.6 | - | - |
| Үгүй | - | - | 10 | 4 | - | - |
| 10-20 мин | - | - | 3 | 1.2 | - | - |
| 21-30 мин | - | - | 3 | 1.2 | - | - |
| 31-60 мин | - | - | 1 | 0.4 | - | - |
| 61-с дээш мин | - | - | 3 | 1.2 | - | - |

Галт тэрэг Зам-Үүд суманд өглөөний 08:45 цагт очдог нь зорчигчид Замын Үүдээс хил гарах дараагийн дамжин суух тээврийн хэрэгсэлд яаралгүй тайван сууж болдог. Замын-Үүдээс УБ хотруу хөдлөх галт тэрэгний цаг 18:05 цагт байдаг. Судалгааны ажиглалтаар иргэд хил нэвтрэх түгжрэлээс болж галт тэрэг хөдлөх цагтай уралдан яаруу сандруу галт тэргэндээ сууж байна. Галт тэргээр зорчигчдын 64.4 хувь нь тээврийн хэрэгслийн өртөөнд хүрч буй эсвэл өртөөнөөс хөдөлж буй цагийн хуваарь нь дараагийн дамжин суух тээврийн хэрэгслийн үйлчилгээний хуваарь, Улсын хил ажиллах хуваарьтай нийцдэг талаар ТИЙМ гэж хариулсан бол 31.6 хувь нь МЭДЭХГҮЙ гэж хариулсан байна. Өмнөговь аймагруу УБ хотоос 16:00 цагт хөдөлж буй автобус шөнө 01:30 цагт аймагт ирдэг. Тус аймагийн авто тээврийн төв нь аймгийн төвөөс нэлээдгүй зайтай зэлүүд газар байдаг тул иргэд шөнө зайлшгүй таксигаар үйлчлүүлэх шаардлагатай болдог.

Хүснэгт 10 №. Тээврийн хэрэгслээр зорчихтой холбоотой болон зам тээвэртэй холбоотой таны гаргасан санал, гомдлыг тухайн байгууллага хүлээн эсэх

| Хариулт | Авто зам /Жолооч/ | | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|----------|-------------------|------|----------------|------|-----------|------|---------------------------|------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Тийм | 16 | 21.6 | 57 | 18.9 | 41 | 16.4 | 63 | 25.4 |
| Үгүй | 25 | 33.8 | 26 | 8.6 | 50 | 20 | 48 | 19.4 |
| Мэдэхгүй | 33 | 44.6 | 219 | 72.5 | 159 | 63.6 | 137 | 55.2 |
| Нийт | 74 | 100 | 302 | 100 | 250 | 100 | 248 | 100 |

Аливаа санал, гомдол нь үйлчилгээг сайжруулах, зөрчлийг арилгахад голлох суурь мэдээлэл болдог. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шийдвэрлэнэ. Шаардлагатай бол яамны Төрийн нарийн бичгийн дарга уг хугацааг 30 хүртэл хоногоор сунгана. Саналын шинжтэй өргөдлийн хариуг 60 хоногт багтаан өгдөг. Судалгаанд тээврийн хэрэгслээр зорчихтой холбоотой болон зам тээвэртэй холбоотой таны гаргасан санал, гомдлыг тухайн байгууллага хүлээн авдаг уу? гэсэн асуултад иргэдийн дийлэнх нь мэдэхгүй гэж хариулсан байна. Үүнд: Жолоочын 44.6 хувь нь, Агаарын тээврийн зорчигчдын 72.5 хувь нь, Төмөр замаар зорчигчдын 63.6 хувь нь, Улс, хот хоорондын тээврээр зорчигчдын 55.2 хувь нь тус тус мэдэхгүй гэсэн хариулт өгсөн байна. Иргэд гомдол санал хүлээж авдаг байгууллага байдаг талаар мэдэхгүй байгаа нь ЗТХЯ болон харьяа байгууллагууд иргэдтэй эргэх холбоотой ажиллаж мэдээллийг хүргэх үйл ажиллагаа дутмаг байгааг харуулж байна. Нөгөөтэйгөөр иргэд зөрчил дутагдалтай холбоотой санал, гомдол гаргахаас төвөгшөөдөг байдал мөн нөлөөлж байна.

Хүснэгт № 11. Тээврийн салбарын байгууллагын үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг үнэлнэ үү.

Үнэлгээний оноо /5- маш сайн, 4- сайн, 3- дундаж, 2- муу/

| № | ТЭЭВРИЙН САЛБАРУУД | Авто зам /Жолооч/ | | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | | Дундаж оноо | |
|----|---|-------------------|---------|----------------|---------|------------|---------|---------------------------|---------|-------------|---------|
| | | Оноо | Давтамж | Оноо | Давтамж | Оноо | Давтамж | Оноо | Давтамж | Оноо | Давтамж |
| | ЕРӨНХИЙ ХҮЧИН ЗҮЙЛС | | | | | | | | | | |
| 1 | Тасалбар авхад хялбар байдал | - | - | 3.9 | 276 | 3.5 | 253 | 4.0 | 244 | 3.8 | 773 |
| 2 | Тасалбарын олдоц | - | - | 3.6 | 272 | 3.3 | 248 | 4.0 | 228 | 3.6 | 748 |
| 3 | ТЗБО, хөнгөлөлт, урамшуулалын мэдээллийн хүртээмж | 3.0 | 57 | 3.4 | 208 | 3.0 | 192 | 3.6 | 159 | 3.3 | 616 |
| 4 | Үйл ажиллагааны талаар олон нийтэд тогтмол мэдээлэх байдал | 3.8 | 58 | 3.5 | 244 | 3.3 | 187 | 3.5 | 156 | 3.5 | 645 |
| 5 | Үйлчилгээтэй холбоотой мэдээлэл ил тод, ойлгомжтой байдал | - | - | 3.6 | 246 | 3.5 | 183 | 3.7 | 170 | 3.6 | 599 |
| 6 | Авсан мэдээллийн үнэн бодит, хангалттай байдал | - | - | 3.7 | 264 | 3.5 | 200 | 3.7 | 191 | 3.6 | 655 |
| 7 | ТХ-н маршрут, чиглэл оновчтой байдал | 3.7 | 66 | - | - | - | - | 3.9 | 212 | 3.8 | 278 |
| 8 | ТХ хуваарьт цагтаа ирдэг эсэх | - | - | 4.6 | 229 | 4.8 | 220 | 4.7 | 222 | 4.7 | 671 |
| 9 | Суудлын дагуу сууж чаддаг эсэх | - | - | 4.9 | 290 | 4.7 | 230 | 4.9 | 235 | 4.8 | 755 |
| 10 | Дамжин суух ТХ-н үйлчилгээний хуваарь, хилийн хуваарьтай нийцдэг эсэх | - | - | - | - | 4.8 | 171 | - | - | 4.8 | 171 |
| 11 | ТХ-р зорчихтой холбоотой, ЗТ-тэй холбоотой гаргасан санал, гомдлыг тухайн байгууллага хүлээн эсэх | 3.2 | 41 | 4.1 | 83 | 3.4 | 91 | 3.7 | 111 | 3.6 | 326 |
| 12 | АТХ-н хууль бус тээвэрлэлтийг зохицуулах байдал | 3.0 | 72 | - | - | - | - | 3.5 | 155 | 3.3 | 227 |
| 13 | Үйлчилгээний ажилчдын түргэн шуурхай байдал | - | - | 3.9 | 302 | 3.8 | 243 | 3.7 | 165 | 3.8 | 710 |
| 14 | Зорчих үеийн ачаа тээш хүлээн авалт, зөөвөрлөлт, түгээлтийн түргэн шуурхай байдал | - | - | 3.5 | 271 | 3.2 | 181 | 3.6 | 187 | 3.4 | 639 |
| 15 | Ачаа тээшний бүрэн бүтэн байдал хангагдсан байдал | - | - | 3.5 | 268 | 3.4 | 180 | 3.7 | 201 | 3.5 | 649 |
| 16 | Ачаа тээшний хүлээн авах үнлгээ, даац хэмжээ | - | - | 3.5 | 257 | 3.3 | 176 | 3.6 | 174 | 3.5 | 607 |
| 17 | ЗТХЯ-ны үйл ажиллагаа, шилэн данс, санхүүгийн ил тод байдал | 3.4 | 74 | 3.3 | 160 | 3.3 | 139 | 3.3 | 115 | 3.3 | 488 |
| 18 | ТХ-н дугаар олгох үйлчилгээ | 3.7 | 74 | - | - | - | - | - | - | 3.7 | 74 |
| 19 | ТХ-н оношлогоо | 3.8 | 74 | - | - | - | - | - | - | 3.8 | 74 |
| | Тээврийн салбаруудын дундаж оноо | 3.5 | | 3.8 | | 3.7 | | 3.8 | | 3.7 | |

Тээврийн салбарын байгууллагын үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг нийт 19 ерөнхий хүчин зүйлсээр үнэлэхэд иргэд дунджаар 3.7 оноо буюу 74 хувьтай гэж үнэлсэн байна. Үйлчилгээний шуурхай байдлыг үнэлэх 19 ерөнхий хүчин зүйлс нь тээврийн салбар бүрд харилцан адилгүй байсан ба сайн оноо авсан үйлчилгээнүүд нэлээд олон байна. Үүнд: Тээврийн салбар бүрт тасалбар худалдан авахад хялбар байдал, 3.8 оноо буюу 76 хувьтай байхад агаарын тээвэрт үйлчилгээний ажилчдын түргэн шуурхай байдал 3.9 оноо буюу 78 хувьтай байна. Мөн тээврийн хэрэгсэл хуваарьт цагтаа ирдэг эсэхт 4.7 оноо буюу 92 хувьтай байна. ТХ-н маршрут, чиглэл оновчтой байдлыг 76 хувьтай гэж жолооч нар үнэлсэн бол Улс, хот хооронд зорчигчид нь тасалбарын олдцыг дунджаар 72 хувь гэж үнэлсэн байна. Ачаа тээшний бүрэн бүтэн байдал хангагдсан байдлыг 70 хувь гэж үнэлсэн байна.

Анхаарвал зохих сайжруулах шаардлагатай хэд хэдэн үйлчилгээ байна. Үүнд: ЗТХЯ-ны үйл ажиллагаа, шилэн данс, санхүүгийн ил тод байдлыг иргэд 66 хувьтай үнэлсэн бол Авто тээврийн хэрэгслийн хууль бус тээвэрлэлтийг зохицуулах байдлыг Улс, хот хоорондын тээврээр зорчигчид 66 хувь, Тээврийн зардлын буцаан олголтын хөнгөлөлт, урамшууллын мэдээллийн хүртээмж 66 хувь байна. Дээрх үзүүлэлтүүдийн нарийвчилсан үзүүлэлтийг хавсралтаас харна уу.


АЮУЛ ОСОЛГҮЙ НАЙДВАРТАЙ БАЙДАЛ

Хүснэгт № 12. ТХ-р аялах үед аюулгүй байдлын зааварчилгаа ил тод эсэх

| Хариулт | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|----------|----------------|------|-----------|------|---------------------------|------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Тийм | 258 | 85.4 | 84 | 33.6 | 116 | 46.8 |
| Мэдэхгүй | 8 | 2.6 | 77 | 30.8 | 68 | 27.4 |
| Үгүй | 36 | 11.9 | 89 | 35.6 | 64 | 25.8 |
| Нийт | 302 | 100 | 250 | 100 | 248 | 100 |

Тээврийн хэрэгслээр аялах үед агаарын тээврийн аюулгүй байдлын зааварчилгаа ил тод байршуулсан байдлыг зорчигчид 85.4 хувьтай гэж үзсэн нь иргэд анхаарал муутай зорчдог болохыг харуулж байна. Агаарын тээврийн зорчигчдын суудал бүрийн ард аюулгүй байдлын зааварчилгааг байршуулсан байдаг. Харин галт тэрэг болон автобусанд аюулгүй байдлын зааварчилгааг дутмаг байршуулсан байсан нь судалгаа үнэлгээний явцад ажиглалтаар тогтоосон үүнийг судалгааны үзүүлэлтүүд мөн нотолж байна. Төмөр замаар зорчигчдын 35.6 хувь нь, Улс, хот хоорондын тээврээр зорчигчдын 25.8 хувь нь аюулгүй байдлын зааварчилгааг ил тод байршуулаагүй гэж үзсэн байна. Аяллын явцад аюулгүй байдлын зааварчилгааг зорчигчдод үйлчилгээний ажилчид танилцуулж зааварчилгаа өгч байх нь хамгийн чухал үйлчилгээ төдийгүй онцгой үед хүний амь нас аврах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авч чадах ач холбогдолтой болно.

График № 6. ТХ-р аялах үед аюулгүй байдлын зааварчилгаа ил тод эсэх




Хүснэгт № 13 Тээврийн хэрэгслээр аялах үед байршуулсан аюулгүй байдлын зааварчилгаа ойлгомжтой байдаг эсэх

| Хариулт | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|----------|----------------|------|-----------|------|---------------------------|------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Тийм | 255 | 84.4 | 81 | 32.4 | 122 | 49.2 |
| Мэдэхгүй | 42 | 13.9 | 55 | 22 | 99 | 39.9 |
| Үгүй | 5 | 1.7 | 114 | 45.6 | 27 | 10.9 |
| Нийт | 302 | 100 | 250 | 100 | 248 | 100 |

Төмөр замаар зорчигчдын 22 хувь, Улс, хот хоорондын тээврээр зорчигчдын 39.9 хувь нь аюулгүй байдлын зааварчилгааны ойлгомжтой байдлыг мэдэхгүй гэж хариулсан байгаа нь зааварчилгааг дутмаг байршуулдаг, ил тод байдаг нь хомс байгааг харуулж байна. Тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудад тавих хяналт, шаардлагыг нэмэгдүүлэх шаардлагтай байна.

График №7 Тээврийн хэрэгслээр аялах үед байршуулсан аюулгүй байдлын зааварчилгаа ойлгомжтой байдаг эсэх




Мөн аливаа аюулгүй байдлын зааварчилгааг бичиг үсэггүй болон ХБИ, хүүхдэд шууд ойлгогдохоор зурагт мессежтэй боловсруулах талаар хойшид анхаарах нь аюул ослын эрсдэлийг бууруулж өгнө.

Хүснэгт № 14. Аюулгүй байдлын зааварчилгааг мөрддөг эсэх

| Хариулт | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|----------|----------------|------|-----------|------|---------------------------|------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Тийм | 264 | 87.4 | 140 | 56 | 164 | 66.1 |
| Мэдэхгүй | 4 | 1.3 | 17 | 6.8 | 26 | 10.5 |
| Үгүй | 34 | 11.3 | 93 | 37.2 | 58 | 23.4 |
| Нийт | 302 | 100 | 250 | 100 | 248 | 100 |

Дээрх хүснэгтээс харахад аюулгүй байдлын зааварчилгааг мөрддөг үү гэсэн асуултанд Агаарын тээврийн зорчигчдын 87.4%, Төмөр замын зорчигчдын 56%, Улс, хот хоорондын тээврийн хэрэгслийн зорчигчдын 66,1% нь ТИЙМ гэж хариулсан байна. Харин аюулгүй байдлын зааварчилгаа байдагийг мэдэхгүй, зааварчилгаа байсан ч ойлгомжгүй болон зааварчилгааг мөрддөггүй, мэдэхгүй гэсэн хариултын хувь Улс, хот хоорондын тээвэр болон Төмөр замд илүүтэй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

График №8. Аюулгүй байдлын зааварчилгааг мөрддөг эсэх




Тээврийн хэрэгслээр зорчиж буй иргэн бүр аюулгүй байдлын зааварчилгааг мөрддөг байх талаар сануулга мессежийг иргэдэд тогтмол өгөх нь судалгаагаар гарсан үр дүнг нэмэгдүүлэх болон ТХ-р зорчих үеийн аюул, эрсдэлийг бууруулах ач холбогдолтой байна.

Хүснэгт № 15. Тээврийн хэрэгслийн буудлын орчинд архидан согтуурсан, танхай этгээдүүд байдаг эсэх

| Хариулт | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|----------|----------------|------|-----------|------|---------------------------|------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Тийм | 14 | 4.6 | 57 | 22.8 | 59 | 23.8 |
| Үгүй | 105 | 34.8 | 31 | 12.4 | 32 | 12.9 |
| Заримдаа | 76 | 25.2 | 97 | 38.8 | 76 | 30.6 |
| Мэдэхгүй | 107 | 35.4 | 65 | 26 | 81 | 32.7 |
| Нийт | 302 | 100 | 250 | 100 | 248 | 100 |

Судалгаанд хамрагдсан агаарын тээврийн зорчигчид тээврийн хэрэгслийн буудлын орчинд архидаг согтуурсан, танхай этгээдүүд байдаг талаар 29,8 хувь нь, Төмөр замаар зорчигчдын 61.6 хувь нь, Улс, хот хоорондын тээврээр зорчигчдын 54.4 хувь нь ЗАРИМДАА болон БАЙДАГ гэж үзсэн байна. Зам тээврийн үйлчилгээний байгууллагууд нь камержуулалт болон аюулгүй байдал, хамгаалалтын ажилтны үйлчилгээг цаашид илүү анхаарч хөгжүүлэх шаардлагатай байгааг дээрх үзүүлэлт харуулж байна.

График №9. Тээврийн хэрэгслийн буудлын орчинд архидаг согтуурсан, танхай этгээдүүд байдаг эсэх



Иргэдийн үйлчилгээ авч буй газрууд болон ойр орчимд аюул эрсдэлгүй байх нөхцөлийг үйлчилгээний байгууллагууд, хууль сахиулах байгууллагууд онцгой анхаарч байх ёстой. Авто зогсоол, авто вокзал, төмөр замын вокзалын ойролцоо нийтийн эзэмшлийн зам талбайд архи уудаг хүмүүс архидаг согтуурах, улмаар согтуугаар иргэдийг айлган сүрдүүлэх, хэл үгээр доромжлох үзэгдэл нэлээдгүй гарч байна.

Хүснэгт №16. Тээврийн хэрэгслийн болон буудлын аюул осолгүй байдал

Үнэлгээний оноо /5- маш сайн, 4- сайн, 3- дундаж, 2- муу /

| № | ТЭЭВРИЙН САЛБАРУУД | Авто зам /Жолооч/ | | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | | Дундаж оноо | |
|---|---|-------------------|---------|----------------|---------|-----------|---------|---------------------------|---------|-------------|------------|
| | | Оноо | Давтамж | Оноо | Давтамж | Оноо | Давтамж | Оноо | Давтамж | Оноо | Давтамж |
| | ЕРӨНХИЙ ХУЧИН ЗҮЙЛС | | | | | | | | | | |
| 1 | Буудлын гадна, дотно гэрэлтүүлэг | - | - | 4.0 | 302 | 3.6 | 250 | 3.5 | 199 | 3.7 | 751 |
| 2 | Авто замын болон Буудлын Камержуулалт | 2.6 | 65 | 4.1 | 292 | 3.7 | 191 | 3.3 | 140 | 3.4 | 688 |
| 3 | Буудлын орчмын халтиргаа гулгаанаас сэргийлсэн байдал | - | - | 4.0 | 298 | 4.1 | 210 | 3.3 | 204 | 3.8 | 712 |
| 4 | Буудлын орчин нь ХБИ, хөгшин настай, хүүхэдтэй иргэдэд ээлтэй орчин үүссэн байдал | - | - | 3.2 | 243 | 2.9 | 192 | 3.0 | 168 | 3.0 | 603 |
| 5 | Буудлын орчим хулгай дээрмээс сэрэмжлүүлсэн байдал | - | - | 3.6 | 300 | 3.2 | 222 | 3.3 | 216 | 3.4 | 738 |

| | | | | | | | | | | | |
|----|---|------------|----|------------|-----|------------|-----|------------|-----|------------|------------|
| 6 | Буудал нь аюулгүй байдалын ажилтантай байдал | - | - | 3.9 | 294 | 3.6 | 217 | 3.4 | 122 | 3.6 | 633 |
| 7 | Буудал нь галын дохиолол болон гал унтраах төхөөрөмжөөр хангагдсан байдал | - | - | 4.2 | 301 | 4.0 | 239 | 4.0 | 193 | 4.1 | 733 |
| 8 | Буудалын аюул ослын үеийн гарц, гарам нүдэнд ил тод байгаа байдал | - | - | 3.7 | 274 | 3.9 | 250 | 3.7 | 162 | 3.8 | 686 |
| 9 | ТХ-н хурд тохиромжтой байдал | - | - | - | - | 3.9 | 248 | 3.9 | 194 | 3.9 | 442 |
| 10 | ТХ нь аюулгүй байдлын зааварчилгаатай эсэх | - | - | 4.6 | 294 | 3.5 | 173 | 3.9 | 180 | 4.0 | 647 |
| 11 | Зааварчилгаа нь ойлгомжтой эсэх | - | - | 4.9 | 260 | 3.4 | 185 | 3.0 | 221 | 3.8 | 666 |
| 12 | Аюулгүй байдлын зааварчилгааг мөрддөг эсэх | - | - | 4.7 | 298 | 3.8 | 233 | 4.2 | 224 | 4.2 | 755 |
| 13 | ТХ-н буудлын орчинд архидан согтуурсан, танхай этгээдүүд байдаг эсэх | - | - | 2.6 | 195 | 3.6 | 185 | 3.5 | 167 | 3.2 | 547 |
| 14 | Үйлчилгээний ажилчид согтууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм тариа, ундаа хэрэглэсэн эсэх | - | - | 4.6 | 168 | 4.8 | 166 | 4.7 | 150 | 4.7 | 484 |
| 15 | ТХ нь Анхны тусламжийн хэрэглэгдэхүүнтэй эсэх | - | - | 4.2 | 295 | 4 | 221 | 3.6 | 98 | 3.9 | 614 |
| 16 | ТХ нь гал унтраах төхөөрөмжөөр хангагдсан байдал | - | - | 4.1 | 258 | 4.0 | 197 | 3.7 | 107 | 3.9 | 562 |
| 17 | Замын аюулгүй байдал, хашилт, гэрэлтүүлэг | 3.5 | 74 | - | - | 3.3 | 169 | - | - | 3.4 | 243 |
| 18 | Замын үер ус зайлуулах хоолой | 2.7 | 69 | - | - | 3.1 | 146 | - | - | 2.9 | 215 |
| 19 | Авто замын гарц, гарамын аюулгүй байдал | 3.2 | 74 | - | - | - | - | - | - | 3.2 | 74 |
| 20 | Замын халтиргаа гулгаанаас сэргийлсэн байдал | 2.8 | 74 | - | - | - | - | - | - | 2.8 | 74 |
| 21 | Авто замын хөдөлгөөнийг зохицуулах гэрлэн дохионы ажиллагаа, байршил | 3.3 | 74 | - | - | - | - | - | - | 3.3 | 74 |
| 22 | Тээврийн хэрэгслийн ачаа тээш хэтрүүлэх байдал | - | - | - | - | - | - | 3.6 | 131 | 3.6 | 131 |
| 23 | Замын засвар шинэчлэлт | 3.0 | 74 | - | - | - | - | 3.3 | 166 | 3.2 | 240 |
| 24 | Замын тэмдэг тэмдэглэгээ хангалттай байдал | - | - | - | - | - | - | 3.3 | 162 | | 162 |
| 25 | Замын чанар, стандарт хангалт | 3.0 | 74 | - | - | - | - | - | - | 3.0 | 74 |
| 26 | Замын хажуугийн түр зогсох талбай | 3.2 | 74 | - | - | - | - | - | - | 3.2 | 74 |
| 27 | Гүүрэн байгууламжийн чанар, даац | 3.2 | 74 | - | - | - | - | - | - | 3.2 | 74 |
| 28 | Замын өргөний хэмжээ | 3.2 | 74 | - | - | - | - | - | - | 3.2 | 74 |
| 29 | Ойр орчимд зорчигчдын аюулгүй байдлыг хангасан байдал | - | - | 4.0 | 302 | 3.8 | 250 | 4.1 | 205 | 4.0 | 751 |
| | Тээврийн салбаруудын дундаж оноо | 3.1 | | 4.0 | | 3.7 | | 3.6 | | 3.6 | |

Тээврийн салбарын хамгийн чухал асуудлын нэг нь аюул осолгүй байдал юм. Зам тээврийн салбарын аюулгүй байдлыг хэрэглэгчээр үнэлүүлэхдээ иргэд аюулгүй зорчих орчин бүрдсэн эсэх, нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарал зэргийг илүүтэй анхаарсан болно.

Хэрэглэгчийн үнэлгээнд тээврийн хэрэгслийн болон буудлын аюул осолгүй байдлыг нийт 29 ерөнхий үзүүлэлтээр нарийвчлан дүгнэсэн бөгөөд дундаж оноо 3.6 байгаа нь 72 хувийн үзүүлэлтийг илэрхийлж байна. Буудлын халтиргаа гулгаанаас сэргийлэх байдалд сайн арга хэмжээ авч байсан бөгөөд 3.8 оноо буюу 76 хувь гэж иргэд үнэлсэн байна. Улс, хот хоорондын тээврийн үйлчилгээний авто вокзалуудын аюул осолгүй ажиллагааны үзүүлэлтүүдийг нэн түрүүнд сайжруулах шаардлагатай байна. Ялангуяа буудлын аюул ослын үеийн гарц, гармыг сайжруулах, нүдэнд ил тод тэмдэг тэмдэглэгээг сайжруулах, Галын дохиолол болон гал унтраах төхөөрөмжөөр бүрэн хангах, аюулгүй байдлын ажилтантай байх, хулгай дээрмээс сэрэмжлүүлэх, камержуулалтыг сайжруулах зэрэг болно. Аюул осолгүй байдал бүрэн хангагдсанаар иргэд сэтгэл амар, ая тухтай үйлчлүүлэх, иргэд болон тээврийн салбарын уялдаа эргэх холбоо сайжирна.


Авто замд анхаарч сайжруулах асуудалд замын халтиргаа гулгааг шуурхай арилгах, замын үер усны зайлуулах хоолойг зам барилгын ажилд анхнаас нь шийдэж өгдөг байх талаар иргэд санал хүсэлтээ хэлж шүүмжилж байлаа.

Хүснэгт №17. Үйлчилгээний ажилчид согтууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм тариа, ундаа хэрэглэсэн эсэх

| Хариулт | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | |
|----------|----------------|------|-----------|------|---------------------------|------|
| | Давтамж | Хувь | Давтамж | Хувь | Давтамж | Хувь |
| Тийм | 8 | 2.6 | 6 | 2.4 | 8 | 3.2 |
| Үгүй | 144 | 47.7 | 150 | 60 | 130 | 52.4 |
| Заримдаа | 14 | 4.6 | 10 | 4 | 12 | 4.8 |
| Мэдэхгүй | 136 | 45.0 | 84 | 33.6 | 98 | 39.5 |
| Нийт | 302 | 100 | 250 | 100 | 248 | 100 |

Тээврийн салбарын үйлчилгээний ажилчид согтууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм тариа, ундаа хэрэглэн үйлчилгээ үзүүлсэн талаар тодруулахад агаарын тээврийн зорчигчид 7.2 хувь нь, Төмөр замаар зорчигчдын 6.8 хувь нь, Улс, хот хоорондын тээврээр зорчигчдын 8 хувь нь ТИЙМ болон ЗАРИМДАА гэж хариулт өгсөн байна. Иргэдийн энэхүү хариулт нь хувийн жингээр бага байгаа ч ЗТХЯ болон харьяа газар байгууллагуудын удирдлагууд анхааралдаа авч ажиллах шаардлагатайг харуулж байна.

График №10 Үйлчилгээний ажилчид согтууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм тариа, ундаа хэрэглэсэн эсэх



ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОЁЛ

Хүснэгт № 18. Тээврийн хэрэгслийн буудлын орчин, хүлээлгийн танхим болон гадна болон дотор орчны нөхцөл байдал

Үнэлгээний оноо /5- маш сайн, 4- сайн, 3- дундаж, 2- муу/

| | ТЭЭВРИЙН САЛБАРУУД | Авто зам /Жолооч/ | | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | | Дундаж оноо | |
|----|---|-------------------|---------|----------------|---------|-----------|---------|---------------------------|---------|-------------|------------|
| | | Оноо | Давтамж | Оноо | Давтамж | Оноо | Давтамж | Оноо | Давтамж | Оноо | Давтамж |
| 1 | ТХ-н буудлын ажиллах цагийн хуваарь | - | - | 4.2 | 302 | 4.2 | 250 | 4.1 | 207 | 4.2 | 759 |
| 2 | Хүлээлгийн танхимын дулаан, агааржуулалт | - | - | 4.1 | 292 | 3.6 | 234 | 3.6 | 209 | 3.8 | 735 |
| 3 | Хүлээлгийн танхимын суудлын хүрэлцээ | - | - | 4.2 | 302 | 3.6 | 250 | 3.3 | 211 | 3.7 | 763 |
| 4 | Гадна, дотор орчны цэвэр цэмцгэр байдал | - | - | 4.2 | 302 | 3.6 | 250 | 3.4 | 233 | 3.7 | 785 |
| 5 | Ариун цэврийн өрөө, хогийн савны хангалт | - | - | 3.8 | 302 | 3.7 | 250 | 3.5 | 228 | 3.7 | 780 |
| 6 | Интернэт холбоо, Wifi хангамж | - | - | 3.2 | 276 | 2.9 | 187 | 2.9 | 146 | 3.0 | 609 |
| 7 | Хоолны газарын хүртээмж | - | - | 3.8 | 302 | 3.7 | 234 | 3.5 | 230 | 3.7 | 766 |
| 8 | Гадна, дотор талын хаяг, заах тэмдэг, тэмдэглэгээ ойлгомжтой байдал | - | - | 3.9 | 302 | 3.3 | 216 | 3.5 | 200 | 3.6 | 718 |
| 9 | ТХ-н буудлын засвар шинэчлэлт | - | - | 3.6 | 300 | 3.2 | 206 | 3.9 | 221 | 3.6 | 727 |
| 10 | Ойролцоо нийтийн тээврийн үйлчилгээний хангалттай байдал | - | - | 3.8 | 301 | 4.1 | 248 | 4.1 | 181 | 4.0 | 730 |
| 11 | ТХ-н буудлын орчмын машины зогсоолын хүрэлцээ | - | - | 4.1 | 302 | 3.5 | 249 | 3.6 | 233 | 3.7 | 784 |
| 12 | Агааржуулалт, халаалт | - | - | 4.1 | 301 | 3.2 | 233 | 3.7 | 216 | 3.7 | 750 |
| 13 | Суудлын хүрэлцээ | - | - | 4.0 | 302 | 3.3 | 242 | 3.8 | 221 | 3.7 | 765 |
| 14 | Зорчих үед зам дагуу бие засах газруудын хүрэлцээ, ариун цэвэр | - | - | - | - | - | - | 3.1 | 217 | 3.1 | 217 |
| 15 | Ойр орчимд зорчигчдын аюулгүй байдлыг хангасан байдал | - | - | 4.0 | 302 | 3.5 | 213 | 3.7 | 203 | 3.7 | 718 |
| 16 | Гадна, дотор орчны цэвэр цэмцгэр байдал | - | - | 4.2 | 302 | 3.8 | 242 | 3.5 | 243 | 3.8 | 787 |
| 17 | Ариун цэврийн өрөөний цэвэр цэмцгэр байдал | - | - | 4.0 | 300 | 3.3 | 250 | - | - | 3.7 | 550 |
| 18 | Интернэт холбоо, Wifi хангамж | - | - | 3.3 | 237 | 3.8 | 250 | 2.8 | 147 | 3.3 | 634 |
| 19 | Хоолны газарын хүртээмж /Зам дагуух болон доторх/ | - | - | 3.8 | 302 | 3.6 | 249 | 3.5 | 235 | 3.6 | 786 |
| 20 | Зам болон ТХ-н гадна, дотор талын хаяг, | 3.7 | 69 | 4.1 | 302 | 3.9 | 250 | 3.8 | 224 | 3.9 | 845 |

| | | | | | | | | | | | |
|----|--|------------|----|------------|-----|------------|-----|------------|-----|-------------------|------------|
| | заах тэмдэг, тэмдэглэгээ ойлгомжтой байдал | | | | | | | | | | |
| 21 | Аялалын талаарх мэдээллийг зарладаг байдал /Дараагийн зогсоол г.м/ | - | - | 4.1 | 302 | 3.0 | 206 | 3.7 | 213 | 3.6 | 721 |
| 22 | Ойролцоо НТҮ, замын ойролцоох дугуй засвар бусад үйлчилгээ хангалттай байдал | 3.6 | 74 | - | - | - | - | - | - | 3.6 | 74 |
| 23 | Тээврийн салбарт үйлчилгээний шинэлэг технологи нэвтрүүлсэн байдал | 3.3 | 74 | 3.9 | 302 | 3.5 | 204 | 3.6 | 214 | 3.6 | 794 |
| 24 | Жолооч, үйлчилгээний ажилтнуудын хувцаслалт, харилцааны соёл | 3.4 | 60 | 4.2 | 302 | 3.8 | 245 | 3.7 | 227 | 3.8 | 834 |
| 25 | Бусад үйлчилгээний ажилчдын хувцаслалт, харилцааны соёл | 3.6 | 74 | 4.3 | 319 | 3.6 | 237 | 3.7 | 210 | 3.8 | 840 |
| 26 | Зам, талбайн цэвэр цэмцгэр байдал | 3.7 | 74 | - | - | - | - | - | - | 3.7 | 74 |
| | Тээврийн салбаруудын дундаж оноо | 3.6 | | 4.0 | | 3.6 | | 3.6 | | <u>3.7</u> | |

Байгууллагын соёлд улс үндэстний онцлог их нөлөөтэй байдаг. Төрийн байгууллагуудад "үүргийн соёл" ихэвчлэн хэрэгждэг. Үүргийн соёл нь байгууллага маш тодорхой бүтэцтэй, хүмүүст ч маш тодорхой эрх мэдэл өгөгдсөн байдаг. Гэхдээ шат дараалсан хүнд сурталтай байдаг. Тухайн хүний албан тушаал нь их эрх мэдлийг дагуулдаг бөгөөд хүн нь ямар байх нь чухал биш. Ийм байгууллагад бүх зүйл дүрэм журам, албан тушаалын шатлалаар зохицуулагддаг. Тогтвортой систем, дүрэм журмуудыг чухалчилдаг. Дүрэм журам хэдий тодорхой цэгцтэй системтэй байна төдий чинээ тухайн байгууллагыг харж, мэдэрч болохуйц шинжүүд болох барилга байгууламж, ажлын орчин, тавилга, шагнал урамшуулал, ажилтнуудын хувцаслалт, хоорондоо болон хэрэглэгчидтэй харьцаж буй байдал, байгууллагын уриа эрхэм зорилго, үйл ажиллагааны тунхаглал зэрэг нь ил тод байдаг.

Хэрэглэгчийн үнэлгээний үйлчилгээний соёлыг нийт 26 ерөнхий үзүүлэлтээр нарийвчлан үнэлж дүгнэн харуулахад дунджаар 3.7 оноо буюу 74 хувийн үзүүлэлттэй байна. Тээврийн хэрэгслийн буудлын ажиллах цагийн хуваарьт иргэд сэтгэл хангалуун ихээхэн өндөр оноог өгсөн ба 4.2 оноо буюу 84 хувь гэж үнэлсэн байна. Үүнд хотын авто вокзал, нисэх буудал, хотын төмөр замын вокзал ажиллах цаг нь иргэдэд ээлтэй үйлчилгээ болж чаддаг байна. Харин авто Дорноговь, Драгон зэрэг авто вокзалуудын ажиллах цаг нь хязгаарлагдмал байдаг тул уртасгасан цагаар ажиллах боломжыг нэмэгдүүлэх талаар иргэд санал бодлоо хэлж байсан.

Ажилчдын харилцаа, хувцаслалт, хандлагын талаарх үйлчилгээний соёл нь сайн боломжийн байгаа хэдий ч техник технологийн шийдэл, хөрөнгө санхүү шаардсан бүтээн байгуулалтын ажил болох иргэдийн тав тухыг илүү хангасан үйлчилгээний соёлууд нь бага зэрэг учир дутагдалтай байна. Зам дагуух ариун цэврийн байгууламж барих, хоолны газруудын хүртээмжийг нэмэгдүүлэх, интернетийн хурдыг нэмэгдүүлж wifi хэрэглээг нэмэгдүүлэх, билет борлуулалтын автомат машин, мэдээллийн технологийн програмчлалын хөгжүүлэлтийг сайжруулж хэрэглээ болгох гэх мэт иргэдийн хүсэлт, шүүмжлэл нэлээдгүй байна.

ҮНЭ, ТАРИФЫН ХЭМЖЭЭ

Хүснэгт №19 Үнэ тарифын үнэлгээ

Үнэлгээний оноо /5- Хямд, 4- Дундаж, 3- Үнэтэй, 2- Хэт үнэтэй /

| № | ТЭЭВРИЙН САЛБАРУУД | Авто зам /Жолооч/ | | Агаарын тээвэр | | Төмөр зам | | Улс, хот хоорондын тээвэр | | Дундаж оноо | |
|---|--|-------------------|---------|----------------|---------|------------|---------|---------------------------|---------|-------------|------------|
| | | Оноо | Давтамж | Оноо | Давтамж | Оноо | Давтамж | Оноо | Давтамж | Оноо | Давтамж |
| | ЕРӨНХИЙ ХҮЧИН ЗҮЙЛС | | | | | | | | | | |
| 1 | Авто машины зогсоолын төлбөр | 3.9 | 74 | 3.9 | 301 | 4.5 | 188 | 4 | 213 | 3.7 | 5.4 |
| 2 | ТХ-н буудлын ариун цэврийн өрөөний төлбөр | 3.8 | 71 | - | - | 3.8 | 206 | 3.8 | 167 | 3.8 | 3.8 |
| 3 | ТХ-н буудал орчмын хоол, хүнсний худалдааны үнэ | 4.2 | 74 | 3.4 | 246 | 3.4 | 250 | 4.0 | 214 | 3.5 | 5.0 |
| 4 | ТХ-р аялах үеийн болон зам дагуух хоол, хүнсний худалдааны үнэ | 3.6 | 61 | 3.4 | 209 | 3.8 | 250 | 4.0 | 230 | 3.5 | 4.9 |
| 5 | Зорчих тасалбарын үнэ | 3.6 | 74 | 3.1 | 249 | 3.9 | 248 | 3.8 | 248 | 3.8 | 4.8 |
| 6 | Авто зам ашиглалтын төлбөр | 3.7 | 74 | - | - | - | - | - | - | 3.3 | 74 |
| 7 | Түлшний үнэ | 3.0 | 74 | - | - | - | - | - | - | 2.7 | 74 |
| 8 | Жолоочийн хариуцлагын АЖД-н үнэ | 3.7 | 74 | - | - | - | - | - | - | 3.4 | 74 |
| 9 | ТХ-н даатгал | 3.7 | 70 | - | - | - | - | - | - | 3.4 | 70 |
| | Тээврийн салбаруудын дундаж оноо | 3.7 | | 3.5 | | 3.9 | | 3.9 | | 3.7 | |

Зам, тээврийн салбарын тулгамдсан асуудлуудын нэг нь үнэ тарифын асуудал юм. Хэрэглэгчийн үнэлгээнд үнэ тарифтай холбоотой олон хүчин зүйлсийг авч үзлээ. Үүнд: Авто машины зогсоолын төлбөр, Авто зам ашиглалтын төлбөр, Жолоочийн хариуцлагын АЖД-н үнэ, тээврийн хэрэгслийн даатгал, Түлшний үнэ, Зорчих тасалбарын үнэ, Тээврийн хэрэгслээр аялах үеийн болон зам дагуух хоол, хүнсний худалдааны үнэ, Тээврийн хэрэгслийн буудал орчмын хоол, хүнсний худалдааны үнэ гэх мэт. Иргэд илүүтэй агаарын тээврээр зорчих тасалбарыг илүү үнэтэй гэж үзэж байгаа бол жолооч нар түлшний үнэ их байгаа тогтвортой биш байнга бага багаар нэмэгдсээр байна гэж байсан. Түүнчлэн авто зам ашиглалтын төлбөр байнга төлдөг ч энэ мөнгө хаана юунд зарцуулагдсан нь тодорхойгүй байдаг талаар жолооч нар ихээхэн гомдоллож байна.

Иргэд зам, тээврийг дагасан үйлчилгээний үнэ тарифыг төдийлөн үнэтэй гэж үзэхгүй байгаа бөгөөд голчлон зорчих тасалбарыг үнэтэй гэж илэрхийлж байна. Манай улс түлшний бодлогын зохицуулалтыг төдийлөн сайн хийж чадахгүй хоёрдогч орнуудаас шууд хараат байгаа нь зорчих тасалбарын үнэнд гол нөлөөлөх хүчин зүйл болж байна. Тээврийн алдаатай тариф нь наад зах нь өөрийн өртгөө нөхөх хэмжээнд барихгүй бол тээвэрлэлтийн байгууллагууд байнгын алдагдалтай ажиллах эрсдэлийг үүрсээр байна. Түүнчлэн логистик нэгдсэн сүлжээгүйн улмаас тээвэрлэлтийн өртөг өндөр гэх мэт бэрхшээлүүд байсаар байна.

IV. БҮЛЭГ ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ 2017 ОНД ХИЙГДСЭН БОЛОН ХИЙГДЭЖ БАЙГАА БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖЛУУДЫН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт № 20. Бүтээн байгуулалтын ажлуудын хэрэглэгчийн үнэлгээ

Үнэлгээний оноо /5- маш сайн, 4- сайн, 3- дундаж, 2- муу /

| № | ҮЙЛ АЖИЛЛАГАА | Дундаж оноо | |
|----|--|-------------|---------|
| | | Оноо | Давтамж |
| 1 | “Тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл”-н хүрээнд иргэд шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, албан татвараа төлөөгүй, техникийн оношилгоонд хамрагдаагүй тээврийн хэрэгслээ татвар төлөлгүйгээр үнэ төлбөргүй хасалт хийлгэх эрхтэй болсон | 4.2 | 463 |
| 2 | Олон улсын шинэ нисэх онгоцны буудал-УБ чиглэлийн 32 км хурдны авто зам барих ажил (Гүйцэтгэл- 54.2%) | 4.0 | 563 |
| 3 | УБТЗ-н галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах автомат хориглолын систем, диспетчерийн төвлөрүүлэлт нэвтрүүлэх ажил (Гүйцэтгэл- 70%) | 4.3 | 576 |
| 4 | УБТЗ-н 200 км гол замын их засварын ажлыг ажлын хүрээнд 50 км замд их засвар хийж гүйцэтгэсэн | 4.1 | 504 |
| 5 | Замын-Үүдэд тээвэр логистикийн төв байгуулах ажил (Барилгын ажлын гүйцэтгэл- 81%) | 3.6 | 334 |
| 6 | Аюулгүй найдвартай, их багтаамжийн нийтийн тээврийг хөгжүүлэх парк шинэчлэлийн ажлын 2017 онд 100 автобус авах зорилтын хүрээнд 43 орон нутгийн тээврийн автобус авсан (Гүйцэтгэл- 70%) | 3.9 | 472 |
| 7 | Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замд өргөтгөл, шинэчлэлийн ажил (Гүйцэтгэл- 40%) | 3.8 | 445 |
| 8 | Туул гол дээгүүрх Баянзүрхийн 288 урт метр болон Сонсголонгийн 289.4 урт метр төмөр бетон гүүр (Гүйцэтгэл- 70%) | 4.0 | 506 |
| 9 | Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй тээврийн шинэ төрөл нэвтрүүлэх ажлыг эхлүүлсэн | 3.9 | 439 |
| 10 | Авто замын арчлалт, засварын ажлыг норм, нормативын дагуу хийж гүйцэтгэсэн | 3.9 | 463 |
| 11 | УБ-Дархан-Алтанбулаг, УБ-Арвайхээр, Дархан-Эрдэнэт, УБ-Чингис, Налайх-Чингис чиглэлийн нийт 504 км авто замд их засвар шинэчлэлийн ажил (Гүйцэтгэл- 65%) | 3.9 | 474 |
| 12 | Нийслэл болон аймгийн төвд улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний авто буудал барих ажил (Гүйцэтгэл- 90%) | 3.9 | 449 |
| | Нийт оноо | 4.0 | |

Зам тээврийн салбарын хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-д өргөн

мэдүүлсэн. Түүнчлэн хэд хэдэн хуулийн төсөл, бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж байгаа хэдий ч 2017 онд эцэслэн боловсруулж дуусгавар болоогүй байна. Үүнд:

- Иргэний нисэх, төмөр замын тээвэр, авто тээвэр, далай ашиглах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслүүд
- Авто зам болон автотээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг шинээр, төмөр замын тээвэр болон иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын баримт бичиг тус тус болно.

Зам тээврийн салбарт 2017 онд хийгдсэн болон хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажлуудын талаарх иргэдийн мэдлэг мэдээлэл дутмаг төдийгүй иргэдэд хүрч байгаа мэдээллүүд нь улс төр болон бусад шалтгааны улмаас үнэн бодит байдлаас хазайсан зөв бодит мэдээлэлтэй иргэд хомс байна. Харин тухайн бүтээн байгуулалтын ажил нь амьдарч, ажиллаж буй газарт нь хийгдсэн талаарх мэдээлэл хангалттай сайн байлаа. 2017 онд өмнөх оны дуусаагүй бүтээн байгуулалтуудыг он дамнан улсын төсвөөр болон гадаадын зээл тусламжаар үргэлжлүүлэн хэрэгжүүлж буй нэлээдгүй олон ажил байна. 2017 он нь томоохон бүтээн байгуулалтын ажлуудын бэлтгэл суурь базаасан олон талын хэлэлцээр хийсэн, банкууд, донор байгууллагуудтай тохиролцсон, засгийн газрын хуралдаанаар тогтоолд тусган батлуулах гэх мэт ажлуудыг нэлээдгүй хийсэн байна.

Иргэд "тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл"-ийн хүрээнд шилжилт хөдөлгөөн хийгдээгүй, албан татвараа төлөөгүй, техникийн оношлогоонд хамрагдаагүй тээврийн хэрэгслээ татвар төлөлгөөгээр үнэ төлбөргүй хасалт хийлгэх эрхтэй болсон үйлчилгээг ихээхэн үнэлж сайшаан 3.7 оноо буюу 74 хувийн үнэлгээг өгсөн байна.

Мөн Иргэд мэдээллийг янз бүрийн харилцан адилгүй сувгаас хүлээн авч байгаа тул ЗТХЯ нь хийгдэх болон хийгдэж байгаа ажлуудын явцын талаарх үнэн бодит мэдээллийг олон сувгийг ашиглан иргэдэд хүргэж байх зайлшгүй шаардлагатай байна.

Харин иргэдээс салбарын үйл ажиллагаа, ололт амжилт, бэрхшээлтэй холбоотой нээлттэй асуулт асуусан бөгөөд иргэд, хэрэглэгчдийн хариултыг доор багцлан хүргэж байна.

Тээврийн салбарт 2017 онд хийгдсэн хамгийн том бүтээн байгуулалтын ажил таны бодлоор юу вэ?

- ✚ Төмөр зам –Дийлэнх хэрэглэгчид сайн мэдэхгүй, мэдээлэл байхгүй /давтамж-100/, хийсэн ажлаа тайлагнадаггүй, бүтээн байгуулалт муу хийгдсэн гэж хариулсан бол харин хийгдсэн ажлуудаас иргэд ТВ ЗУРАГТТАЙ, USB холболтоор утас цэнэглэдэг, WiFi-Утасгүй интернэт, КАМЕРТАЙ болсон, Үйлчилгээ, сахилга бат сайжирсан, Замын-үүдийн Фероны шинэчлэл хийгдсэн, Олон овоо өртөөний терминалын ажил, Туул гол дээгүүрх Баянзүрхийн 288м гүүрын ажил, Сонсголгонгийн бетонон гүүр, Тээвэр зуучийн төв, УБ Хүлээлгийн танхим г.м томоохон бүтээн байгуулалтууд хийсэн. Харин хийсэн бүтээн байгуулалтын ажлыг тууштай богино хугацаанд хийвэл сайн гэж хариулжээ.
- ✚ Агаарын тээвэр –Мэдээлэл муу учир мэдэхгүй гэж дийлэнх нь хариулсан бол /Давтамж-51/, 1 онгоц түрээсэлсэн, Шинэ нисэх онгоцны буудал барьж байгаа /Давтамж-50/, Чингис хаан нисэх бүүдлын засвар, Хурдны зам, Бусан, Бангкок,

Бугатын чиглэлийн шинэ нислэг, Тоног төхөөрөмжөө өөрсдөө засдаг гэх мэт ажлуудыг дурджээ.

- ✚ Улс, хот хоорондын тээвэр –Маш муу, мэдэхгүй /40/ гэж хариулсан бол зарим хэрэглэгчид үйл ажиллагаандаа ахиц гарган шинэчлэл хийж байгаа гэж хариулсан байна. Мөн Эрхүү-УБ-н төмөр замын сайжруулалт, Туул гол дээгүүрх БЗ-н гүүр, Аймгуудыг холбосон автозам, Бага болон дунд оврын автобусыг халж том болгосон, БЗД-н авто вокзал шинэчлэгдсэн, Бүх аймгуудруу автобус явдаг болсон, Зам засварын ажил сайн хийгддэг болсон, Тээврийн хэрэгслийн парк шинэчлэлт хийгдсэн гэж хариулжээ.
- ✚ Авто зам –Дийлэнх хэрэглэгчид хангалтгүй, мэдэхгүй гэж хариулсан бол цөөн хэрэглэгчид аймаг хот хоорондын замын ажил, Толгойтын замын засвар, хот хоорондын автобус сайжирсан, цахим төлбөр тооцооны хэлбэрт шилжсэн гэж хариулжээ.

Аль нэг тээврийн хэрэгслээр зорчиход танд хамгийн их тулгардаг бэрхшээл юу вэ?

✚ Төмөр зам

-00-н ариун цэвэр, хүрэлцээ муу, билет авахад хүндрэлтэй /Хүссэн суудлаа авч чадахгүй байх/, ачаалалтай үед билетийн олдоц муу, суудлын хүрэлцээ муу, шаглаж зардаг, WiFi муу, Агааржуулалт тааруу /Давтамж -45/, Ачаалал их, суудлын хүртээмж муу /олонх нь/, галт тэрэгний үйлчлэгч, цагдаагийн харилцаа, хандлага тааруу /олонх/, хаалгыг хөдлөх тулгаж онгойлгодог, Хэтэрхий халуун, хэтэрхий хүйтэн, жижиг ачааг тээшинд өг гэж загнадаг, урд, хойд хил дээр амардаг байртай болох, Амгалан өртөөнд камерийн хяналт байхгүй /ачаа алддаг/, онлайннар билет авахад банкны төхөл асуудалтай, түгээмэл банкаар байвал зүгээр /хаан, хас, төрийн банк/, Ачаа тээш өгөх, хүлээн авахад хүндрэлтэй байна гэсэн бэрхшээлүүдийг хэлж байна.

✚ Агаарын тээвэр

Тасалбар олдоц муутай, хэт үнэтэй, аюулгүй байдалын баталгаа, Орон нутгийн нислэг хэт халуун, суудал давчуу, хүлээлгийн танхим тав тух муутай, харилцааны соёл хангалттай сайн биш, үзвэр тааруу, мэдээллийн самбар муу, орон нутгийн нислэгийн хоол хүйтэн, хөнжил байхгүй, нгоцны буудал дээр интернэт байхгүй, мэдээлэл иргэдэд тааруу хүргэдэг, хүллэлгийн танхимд тээш хадгалах хэсэг байхгүй гэсэн бэрхшээлүүд дурдсан байна.

✚ Улс, хот хоорондын тээвэр

Агааржуулалт муу, зорчигчид архи уудаг, цэвэрлэгээ муу, замаас хэтэрхий олон зорчигч авдаг, зам дагуух ариун цэврийн байгууламжийн хүрэлцээ, цэвэрлэгээ муу, баярын үеийн ачааллыг зохицуулах, авто вокзал сайжруулах /суудлын хүрэлцээ тааруу/, Вокзалын орчмын хулгай, Жолоочид тамхи татах, зам засвар муу, хүн суулгах, буулгах, тээвэрлэх үеийн зохион байгуулалт, зам дагуух хоолны амт, чанар, аюулгүй байдал тааруу гэсэн байна.

✚ Авто зам

Авто тээврийн байгууллагын дарамт их, тээвэр зохицуулагч, улсын байцаагчдын харилцаа хандлага тааруу, замын хураамж их авдаг /Таван толгой, Гашуун сухайт/, Авто вокзалын зогсоолын хүрэлцээ тааруу, жолоочид замд явахдаа гэрэл шилжүүлэхгүй байх,

даатгалын байгууллагын нөхөн олговор муу, зам ашиглалтын төлбөрийн зарцуулалтаа тайлагнадаггүй, зам засвар тааруу, замын нөхцөл байдал муу /хэт нарийн, тусгаарлах зурвас бүдэг, эвдрэл, халтиргаа гулгаа их, тэмдэг тэмдэглэгээ муу/, мэдээлэл өгөх байдал муу, хулгайн тээврийн асуудал хүндрэлтэй гэжээ.

Тээврийн үйлчилгээни чанар, үйл ажиллагаа, менежмент, хүртээмжийг сайжруулах боломж, нөхцлийн талаар таны санал, хүсэлт?

 Төмөр зам

- 00-н ариутгал, цэвэрлэгээг сайжруулах
- Агааржуулалтыг сайжруулах
- Интернэтийн хурдыг сайжруулах
- Баярын үеийн тээврийн болон суудлын вагоны ачааллыг зохицуулах
- Хүлээлгийн танимыг сайжруулах
- Билет авах өөртөө үйлчилдэг машин тавих
- Гадны сайн туршлагыг судлан хэрэгжүүлэх
- Үйл ажиллагаа, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах
- Замын-Үүдээс УБ явах чиглэлийн вагоны цагийг хойшлуулан 20,0 цаг болгох
- Хурдан галт тэрэгтэй болох
- Иргэдэд чиглэсэн мэдээлэл сайн өгөх
- Үйлчилгээний ажилтнуудын харилцаа хандлагыг сайжруулах
- Суудлыг 3-р давхрын местэнд бичихгүй байх

 Агаарын тээвэр

- Аймаг бүрийг агаарын тээврээр холбох
- Тасалбарын үнийг бууруулахад дорвитой ажиллах
- Аюулгүй найдвартай байдлыг нэмэгдүүлэх
- Хүлээлгийн танхимыг тохижуулан цэвэр ус, интернэт хангамж, тээш хадгалалт, Хүүхэд саатуулах тглоомын хэсэг г.м шийдвэрлэн ОУ-н үйлчилгээнд ойртох
- Ачаалалтай үед бүртгэгчийн тоог нэмэгдүүлэх
- Мэдээлэл хүргэх сувгаа нэмэгдүүлэн, хүртээмжтэй болгох
- Зогсоолийг тодорхой хугацаанд үнэгүй болгох
- Хаанаас юуг лавлах талаарх мэдээлэл өгөх
- Шинэ техник технологи нэвтрүүлэх

 Улс, хот хоорондын тээвэр

- Орон нутагт очиход шөнө очиход хүндрэлтэй тул цагийн зөв зохион байгуулалтад оруулах
- Хүлээлгийн танхимын суудал хүрэлцээ тав тухыг сайжруулан шөнө ажиллах хугацааг уртасгах
- Жолооч үйлчлэгчдийн харилцаа, биеэ авч явах байдлыг сайжруулах
- Авто замын аюулгүй байдал, засвар шинэчлэлтийг сайжруулах
- Иргэдийг соёлтой үйлчлүүлэхэд нөлөөллийн ажил хийх

- Үйл ажиллагааны менежментийг сайжруулан, цэвэр өрсөлдөөнийг бий болгох
- Холын аймгуудад унтлагын автобус явуулах
- Интернэтээр билет захиалга хийхэл гарч буй хүндрэлүүдийг багасгах, эргээд хариулдаг мэдэгддэг болох

✚ Авто зам

- Тээврийн байцаагч нар нь торгох эрхгүй нь хулгайн тээврийг гааруулж байна
- 2 вокзалын орлогыг тэнцвэржүүлэх зорилгоор зүүн вокзалруу шилжүүлсэн нь буруу
- Хулгайн тээврийг зохицуулах механизмыг сайжруулах
- Ажилтнуудын хүнд суртал, харилцааны доголдлыг сайжруулах зорилготой шат дараалласан сургалт хийх
- Зам барилгын ажлын чанарыг нэмэгдүүлэх
- Жолоочийн нас хэт залуу байх нь эрсдэл дагуулж байгаа учир насны хязгаар зааж өгөх
- Жолоочийн ур чадварыг сайжруулах
- Мэдээ, мэдээллийг сайн түгээх болон иргэд хэрэглэгчдийн саналыг хүлээн авдаг тогтолцоог нэвтрүүлэх /Шууд угасаар, Вэб сайтаар/
- Үйл ажиллагааны менежментийг сайжруулах
- Холийн замд 100км тутамд машин амрах зогсоолыг шийдэж өгөх

Шинэ зам тавигдснаар:

- ❖ -Мөнгөнд хэмнэлттэй
- ❖ -Аваар осол багасгах
- ❖ -Ая тухтай зорчих
- ❖ -Автомашин эвдрэл, гэмтэл бага
- ❖ -Улс орны хөгжилд нэмэртэй
- ❖ -Цаг хугацаа хэмнэх ач холбогдолтой байна.

ЗТХЯ-ны үйл ажиллагаа, үйлчилгээ, менежмент, хүртээмжийг сайжруулах боломж, нөхцлийн талаар таны санал, хүсэлт?

- ✚ -2017 онд хийгдсэн ажлуудыгаа бүтээмжийг сайжруулах, мөн хийж буй ажлын менежмент, зохион байгуулалтыг сайжруулах
- ✚ Авто болон төмөр замын чанарыг сайжруулах (хүртээмж, аюулгүй байдал)
- ✚ Авто замаа явган хүний замаас ялгах тусгай тэмдэг тэмдэглэгээтэй болгох гэх мэт
- ✚ Авто машины замыг өргөтгөх, Давхар зам, нэмэлт зам тавих
- ✚ Авто зам болон төмөр замыг хөгжүүлж бүх аймагт төмөр зам тавих
- ✚ Аюулгүй байдлыг сайн сахих хэрэгтэй
- ✚ Боловсон хүчний чанарт сайн анхаарах
- ✚ Иргэд, хэрэглэгчдэл үйл ажиллагааныхаа талаар мэдээллийг ил тод нээлттэй хүргэж байх,
- ✚ Иргэдийг санал бодлыг асуух
- ✚ Үйлчилгээний ажилтануудын харилцаа, соёл дээр анхаарах
- ✚ Үйлчлүүлэгчдэд хүндрэлгүй, хурдан шуурхай болгох, шинэлэг технологи нэвтрүүлэх
- ✚ Шилэн данс ил тод байдал

- ✚ Орон нутгийн авто тээврийн төвүүдтэй хамтран ажиллах, Салбар байгууллагуудтай үйл ажиллагааны уялдаа холбоогоо сайжруулах
- ✚ Тасалбар өгдөг газрыг уб хотод хэд хэдэн газар байршуулах
- ✚ нээлттэй явуулж төсөл тендерээр сайн чанартай зүйл хийх мөнгөө зөв зарцуулах
- ✚ Төрийн өмчийг хувьчлах
- ✚ Хотын төв болон нисэх буудал хүртлэх нийтийн тээврийг хөгжүүлэх
- ✚ Хууль дүрмээ мөрддөг болох


V БҮЛЭГ. ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛСЭН БОДЛОГО, СТРАТЕГИ, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД ӨГСӨН ЭКСПЭРТИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт №21. Зам, тээврийн салбарт хэрэгжүүлсэн бодлого, стратеги, тэдгээрийн хэрэгжилтийн нөхцөл байдалд өгсөн экспэртийн мэдээлэл

| № | | Давтамж | Хувь | |
|-------------|---------------------------|------------------|------------|------|
| 1 | Тээврийн салбар | Авто зам, тээвэр | 8 | 44.4 |
| | | Төмөр зам | 6 | 33.3 |
| | | Агаарын тээвэр | 4 | 22.2 |
| 2 | Боловсрол /Эрдмийн зэрэг/ | Бакалавр | 8 | 44.4 |
| | | Магистр | 5 | 27.8 |
| | | Доктор | 2 | 11.1 |
| | | Мэргэшсэн зөвлөх | 3 | 16.7 |
| 3 | Мэргэжил | Инженер | 12 | 66.7 |
| | | Механикч | 2 | 11.1 |
| | | Санхүү | 1 | 5.6 |
| | | Эрх зүйч | 3 | 16.7 |
| 4 | Салбартаа ажилласан жил | 5-10 жил | 7 | 38.9 |
| | | 11-20 жил | 4 | 22.2 |
| | | 21-с дээш жил | 7 | 38.9 |
| Нийт | | 18 | 100 | |


Зам, тээврийн салбарт ажилладаг мэргэшсэн ажилдаа 5-с доошгүй жил ажилласан мэргэжилтнүүдээс Экспертийн судалгааг авсан нийт Агаарын тээвэр (22%), Төмөр зам (33%), Автозам, тээврийн (42%) 18 хүнээс судалгаа авч ажилласан. Эдгээр мэргэжилтнүүдийн 39% нь салбартаа 21-с дээш жил ажилласан, үлдсэн 61% нь 5-20 жил ажилласан зөвлөхүүд байлаа.

График №11. Судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн салбартаа ажилласан жил, харьяалагдах тээврийн салбар



Зам, тээврийн салбарт хэрэгжүүлсэн бодлого, стратеги, тэдгээрийн хэрэгжилтийн нөхцөл байдалд өгсөн экспертүүд нь салбартаа 5-аас дээш жил ажилласан салбараа сайн мэддэг зөвлөх болон мэргэжилтнүүд байснаас гадна мэргэжил боловсролын хувьд Мэргэшсэн зөвлөх (17%), Бакалавр зэрэгтэй (44%) Магистр зэрэгтэй (28%) Доктор зэрэгтэй (11%), Эрх зүйч, Санхүүч, Инженэр, Механикийн мэргэжилтэй хүмүүс байсан.

График №12. Судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн /Эксперт/ зэрэг цол, мэргэжил



Нийт мэргэжилтнүүдийн 78% нь Инженэр, Техникч буюу салбарын мэргэшсэн хүсүүс хамрагдсан нь салбарын тулгамдсан асуудлыг олж харах, бодлого хөтөлбөр, үйл ажиллагааны үр нөлөөг үнэлүүлэхэд хялбар байлаа.

ЗТХЯ-ны 2017 оны бодлого, стратегийн бичиг баримт хэрэгжилтэд салбарын мэргэшсэн ажилтан, мэргэжилтнүүдээс өгсөн ерөнхий үнэлгээ

Хүснэгт №22 Бодлого, стратегийн бичиг баримтын хэрэгжилтэд экспертүүдийн өгсөн үнэлгээ

Үнэлгээ - (Маш сайн -5; сайн -4; дундаж -3; муу-2; мэдэхгүй - 0)

| Бодлого, стратегийн бичиг баримтууд | Чанар | Гүйцэтгэл | Эдийн засгийн үр өгөөж | Оноо |
|--|-------|-----------|------------------------|------------|
| | Оноо | Оноо | Оноо | |
| Монгол улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилт | 3.9 | 3.7 | 3.4 | 3.6 |
| Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал, түүний хэрэгжилт | 3.8 | 3.7 | 3.5 | 3.6 |
| Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр | 3.6 | 3.6 | 3.5 | 3.5 |
| Монгол улсын зам, тээврийн салбарт баримталж буй бодлого, стратегийн хэрэгжилт | 3.6 | 3.5 | 3.6 | 3.5 |
| Монгол улсын эдийн засаг, | 3.4 | 3.2 | 3.5 | 3.3 |

| | | | | |
|--|-----|-----|-----|------------|
| нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэл | | | | |
| Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого | 3.6 | 3.5 | 3.7 | 3.6 |
| Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого | 3.4 | 3.3 | 3.4 | 3.3 |
| Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги 2012-2020 | 3.5 | 3.5 | 3.8 | 3.6 |

ЗТХЯ-ны салбарын экспертүүд зам тээвэртэй хамааралтай Монгол улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрүүдийн хэрэгжилтийг 78 хувийн чанар гүйцэтгэлтэй байгаа гэж үнэлж байна. Салбарын экспертүүд ЗТХЯ-ыг бусад яамтай харьцуулахад ажил хийдэг яам гэж дүгнэн ярьж байсан. Улсын хэмжээнд Авто замын тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль, Агаарын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Далай ашиглах тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Цөмийн энергийн тухай, Төмөр замын тээврийн тухай хууль, Улсын нисэхийн тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай гэсэн 15 хуулиудын дагуу хэрэгжүүлэх 78 заалтуудаас 53 нь бүрэн хэрэгжиж, 4 нь 70 хувьтай, 16 нь 30 хувьтай 4 нь огт хэрэгжиж эхлээгүй байна¹.

Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаал, түүний хэрэгжилт нь 2017 онд 76 хувийн чанар, гүйцэтгэлтэй байна гэж экспертүүд үзэж байна. Сайдын тушаал, түүний хэрэгжилт нь бусад хууль, тогтоомж шийдвэрээс илүү бодитой хэрэгждэг гэж салбарын мэргэжилтэн албан хаагчид үзэж байна. ЗТХС-дын тушаалын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээг ХШҮДАГ-с тогтмол хийж, санал зөвлөмжийг боловсруулан газар, хэлтэс, харьяа байгууллагуудад хүргүүлэн тушаалын хэрэгжилтийг хангуулан ажилладаг байна. Түүнчлэн ЗТХС-дын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайланг ЗТХЯ-ны сайтад байршуулан олон нийтэд ил тод нээлттэй байлгаж байгаа нь сайшаалтай байна.

Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг экспертүүд чанар болон гүйцэтгэл 72 хувь, Эдийн засгийн үр өгөөж нь 70 хувьтай гэж тус тус үнэлсэн, түүнчлэн Монгол улсын зам, тээврийн салбарт баримталж буй бодлого, стратегийн хэрэгжилтийн чанар 72 хувь, гүйцэтгэл 70 хувь, эдийн засгийн үр өгөөж 72 хувь гэж тус тус үнэлсэн нь 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжихүйц, судалгаа нотолгоонд суурилсан бодитой боловсруулсан хөтөлбөр болсон ба хөтөлбөрийг хэрэгжүүлэх, зам, тээврийн салбарт баримталж буй бодлого, стратегийн хэрэгжилтийг хангуулж ажиллахад ЗТХЯ-ны шийдвэр гаргагчид, мэргэжилтнүүдийг сайн ажиллаж байгаа нь хөндлөнгийн үнэлгээнээс харагдаж байна. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээ, ажлыг тогтоосон аргачлал, зааврын дагуу хийж, албажуулан 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 01/417 тоот

¹ЗТХЯ-ны 2017 оны жилийн эцсийн тайлан

²ЗТХЯ-ны 2017 оны жилийн эцсийн тайлан

албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн байна. ЗТХЯ-ны Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2017 оны хэрэгжилт зарим төлөвлөсөн ажлууд нь он дамжсан судалгаа шинжилгээ, үнэлгээ, тендер шалгаруулалт, гэрээ хэлцэл, шийдвэр гаргалтын түвшинд явагдаж байгаа ба дийлэнх ажлууд 70-100 хувь гүйцэтгэлтэйгээр хийгдсэн байна.

Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын хэрэгжилтийг экспертүүд дунджаар 72 хувьтай гэж үнэлсэн ба “Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-ыг Засгийн газрын хэмжээнд хэрэгжүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээг тусгасан төлөвлөгөөг 2013 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Засгийн газрын 428 дугаар тогтоолоор батлуулсан. Уг бодлогод нийт 58 заалтыг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд тухайн жилд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган ажиллаж байна. 2014 онд улсын төсөвт 24.6 тэрбум, 2015 онд 12.3 тэрбум, 2016 онд 13.5 тэрбум төгрөгийг, 2017 онд агаарын тээврийн зайлшгүй үйлчилгээ үзүүлэх, татаастай нислэг гүйцэтгүүлэхэд 2.1 тэрбум төгрөгийг Иргэний нисэхийн ерөнхий газрын төсөвт, нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Завхан, Говь-Алтай аймгийн нисэх буудлын хөөрч буух зурвас, үерийн далан барих, олон улсын нисэх буудлыг ашиглалтад оруулахад шаардлагатай Монголын талын хөрөнгө оруулалтаар барих барилга байгууламж барих зэрэг ажилд нийт 21.2 тэрбум төгрөг Монгол Улсын 2017 оны Улсын төсөвт тусган санхүүжүүлж байна². Түүнчлэн Иргэний нисэхийн байгууллагуудад Эдийн засаг бодлого, зохицуулалтын хэлтэс байдаг ч үндэсний авиа компаниуд ашигтай ажиллаж чадахгүй байгаа. Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт авиа компаниудыг дэмжих эдийн засгийн зөв бодлого, зохицуулалтыг сайн тусгаж өгөх шаардлагатай байгаа.

Агаарын тээврийн нэг чухал асуудал болох "ШУВУУНЫ ДАЙРАЛТ" гэж ярьдаг буюу шувуутай онгоц мөргөлдөх асуудал байна. Сүүлийн жилүүдэд Монгол улсад онгоц шувуутай мөргөлдөж буй тохиолдлууд ихсэж байгаа. Одоо ашиглагдаж буй Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлыг тойроод олон байшин барилга баригдаж, жижиг үйлдвэр цехүүд дагаж баригдан үйл ажиллагаагаа идэвхтэй явуулан хог ихээр үйлдвэрлэж байгаа. Тухайн байгууллага, оршин суугчдын хогон дээр болон үхсэн малын сэг зэм дээр шувуу ихээр цугларч байгаа нь онгоц хөөрч, буух явцад шувуутай мөргөлдөх эрсдэл өссөн байна. Олон улсын түвшингөөр шувуутай мөргөлдөх эрсдэл 15-20 хувь байдаг бол Монгол улс нислэг багатай ч онгоц шувуутай мөргөлдөх асуудал олон улсаас 3 дахин илүү эрсдэлтэй байгаа бөгөөд 100 нислэгт 7 тохиолдож байгаа нь уг эрсдэл өндөр байгааг харуулж байгаа юм. Энэхүү эрсдэлтэй асуудлыг бууруулахад салбар хоорондын хамтын ажиллагаа сул байгааг сайжруулах болон Байгаль орчны яам, дүүргийн хог тээврийн байгууллагууд, Нийслэлийн хот тохижилтын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн мэргэжлийн хяналт гэх мэт байгууллагуудын үр дүнтэй хамтын ажиллагаа чухал байна. Хамтын ажиллагааны талаар ЗТХЯ нь сул ажиллаж байгаа нь салбарын мэргэжилтнүүдийн судалгаанаас харагдаж байна.

²ЗТХЯ-ны 2017 оны жилийн эцсийн тайлан

Төрөөс ТӨМӨР ЗАМЫН тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг экспертүүд чанар, гүйцэтгэл, эдийн засгийн үр өгөөжийг 72 хувь гэж тус тус үнэлсэн байна. “Төмөр замаар ачаа дамжуулан тээвэрлэх нөхцөлийн тухай Монгол Улсын Засгийн Газар, Оросын Холбооны Улсын Засгийн Газар хоорондын хэлэлцээр”-ийн талаарх яриа хэлэлцээ олон удаа гацаанд орж байсан ч Монголын тал ихээхэн хүчин чармайлт гаргаж тууштай ажилласны үр дүнд хоёр улсын тээврийн салбар хариуцсан яамд Хэлэлцээрийн төслийг 2017 оны 08 дугаар сарын 29-ны өдөр эцэслэн тохиролцсон байна. Нарийнсухайт-Шивээхүрэнгийн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг “Мөнгөн зөрлөг” ХХК нь 2017 оны 05 дугаар сард гэрээ байгуулан шинэчилсэн. Тус чиглэлийн төмөр замын шугамын чигийг Засгийн газрын 2017 оны 126 дугаар тогтоолоор батлуулсан байна.

ЗТХЯ нь тээвэр логистикийн бодлого үйл ажиллагааг төлөвлөхдөө "Улаанбаатар төмөр зам" хувь нийлүүлсэн нийгэмлэгийн бодлого саналыг илүүтэй тусгахаас гадна төмөр замаар тээвэрлэлт хийдэг, худалдаа эрхэлж буй аж ахуй нэгж байгууллагуудын саналыг сонсч, тэдний саналыг тусгаж байх нь чухал юм. Жишээлбэл тээвэрлэлтийн үнэ тариф байнга хэлбэлздэг тогтвортой байдаггүй, жил бүр нэмэгдэж байдаг. Бусад улс оронд тээврийн компаниуд нэгдэж тээвэрлэлтийн зардлууд буурч байгаа жишиг байгаа тул энэхүү асуудалд эрх зүйн тодорхой зохицуулалт хэрэгтэй байна. Логистикийг зөвхөн төмөр замаар биш агаараар, автотээврээр давхар хөгжүүлэх шаардлагатай байна. Логистикийн компаниудын холбоо, эсвэл Худалдаа аж үйлдвэрийн танхимын гадаад дотоод худалдан авалт хариуцсан экспертүүдийн дүгнэлт, санал зөвлөмжөөр чиглэл авч ажиллаж байна. ЗТХЯ-аас логистикийн компаниудыг тээвэр зуучид чиглэсэн бодлого хомс байсаар байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги 2012-2020 хэрэгжилтийг экспертүүд чанар, гүйцэтгэлийг 70 хувь, эдийн засгийн үр өгөөжийг 76 хувь гэж тус тус үнэлсэн байна. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохицуулах Үндэсний хороог Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар шинэчлэн дунд хугацааны болон 2017 оны төлөвлөгөө, зөвлөмжийг Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлж баруун гар талдаа жолооны хүрдтэй, насжилт өндөр бүхий тээврийн хэрэгслийг хязгаарлах чиглэлээр санал боловсруулан Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 11, 03 дугаар сарын 29-ний хуралдаанд танилцуулж, 04 дүгээр сарын 14-ний өдрийн УИХ-ын хуралдаанаар “Онцгой албан татварын тухай хууль”-д автомашины үйлдвэрлэгдсэн он болон хөдөлгүүрийн цилиндрийн багтаамжийг харгалзан татвар ногдуулахаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Улсын хэмжээнд 2017 онд тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 1532 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулахад улсын хэмжээнд 14 хувиар, нийслэлд 28.5 хувиар тус тус буурсан боловч орон нутагт 1.02 хувиар өссөн байна³. Тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2017 онд Өмнөговь аймагт 69, Дундговь аймагт 27, Дорноговь аймагт 60 тохиолдол тус тус бүртгэгдээд байна. Түүнчлэн орон нутгийн замд бүртгэгдсэн осол Дундговь аймагт 75, Дорноговь аймагт 222, Өмнөговь аймагт 207 тохиолдол бүртгэгдсэн байна⁴. Зам тээврийн ослын улмаас амь нас хохирсон

³Монгол улсын үндэсний Статистикийн хороо, статистикийн мэдээллийн нэгдсэн сан

⁴Замын цагдаагийн албаны сайтны статистик мэдээлэл

хүний тоо Улсын хэмжээнд 507 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны үзүүлэлтээс 5,8 хувиар, орон нутагт 12,2 хувиар тус тус өсч, нийслэлд 11.8 хувиар буурсан үзүүлэлт гарч байна⁵.

Дээрх үзүүлэлтэд тодорхойлогдсон осол гэмтлийн өсөлт нь экспертүүд болон хэрэглэгчдийн чанарын ярилцлага, ажиглалтын үндсэн дээр дараах хүчин зүйлсүүдээс үүдэлтэй байгааг илрүүллээ. Үүнд:

- Орон нутгийн авто замын эвдрэлийн засвар удаан
- Хурд хэтрүүлэлт
- Холын гэрэл шилжүүлэхгүй явах
- Ачааны даац хэтрүүлэн явах
- Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох
- Жолоочийн хариуцлага, анхаарал сонор сэрэмж муугаас
- Мал, амьтан зам дээр бэлчээрлэх
- Иргэдийн болгоомжгүй байдал
- Зам засах асфалтыг хотоос тээвэрлэн замын компани ирж засдаг бөгөөд хотоос тээвэрлэж ирсэн чанаргүй асфалт амархан хурдан эвдэрдэг. Үүнээс үүдэн замын чанар муу осол аваар гарах нэг шалтгаан болдог.

ЗТХЯ болон тээврийн бусад салбаруудын үйл ажиллагааны 2017 оны ерөнхий үзүүлэлтүүдийг үнэлсэн байдал

Хүснэгт №23. 2017 оны үйл ажиллагааны ерөнхий үнэлгээ /Нийт 18 эксперт оролцсон ба мэдэхгүй гэсэн хариултыг үнэлгээнд оруулж тооцоогүй болно. /

(Маш сайн -5; сайн -4; дундаж -3; муу-2; мэдэхгүй - 0)

| № | Үзүүлэлт | Үнэлгээ | | | | | | |
|---|---|---------|---|---|---|---|--------|------|
| | | 5 | 4 | 3 | 2 | 0 | Дундаж | Хувь |
| 1 | Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтэц зохион байгуулалт | 4 | 6 | 8 | - | - | 3.7 | 74 |
| 2 | Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны зорилго, зорилт | 4 | 7 | 5 | - | 2 | 3.9 | 78 |
| 3 | Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагаа, бодлого, төлөвлөлтийн ил тод, нээлттэй байдал | 3 | 2 | 8 | 3 | 2 | 3.3 | 66 |
| 4 | Зам, тээврийн хөгжлийн яамны үйл ажиллагааны инноваци, шинэ арга техник, технологи ашиглаж буй байдал | 4 | 2 | 9 | 2 | 1 | 3.4 | 68 |
| 5 | Зам, тээврийн хөгжлийн яамны стратеги зорилтууд төсөвтэйгээ уялдаж буй байдал | 5 | 1 | 8 | 1 | 3 | 3.6 | 72 |
| 6 | Зам, тээврийн хөгжлийн яам болон бусад тээврийн салбар байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа | 3 | 5 | 5 | 3 | 2 | 3.5 | 70 |
| 7 | Зам, тээврийн хөгжлийн яам болон бусад тээврийн салбар байгууллагуудын ажилчдын ажлын мэдлэг, ур чадвар, ажлын хариуцлага | 1 | 5 | 9 | 2 | 1 | 3.2 | 64 |
| 8 | Зам, тээврийн хөгжлийн яам болон бусад тээврийн салбар байгууллагуудын албан хаагчдын харилцааны соёл, ёс зүйн байдал | 3 | 8 | 4 | 3 | - | 3.6 | 72 |
| 9 | Зам, тээврийн хөгжлийн яам болон бусад тээврийн салбар байгууллагуудын албан хаагчдын цалин урамшууллын систем ажлын | 2 | 3 | 6 | 5 | 2 | 3.1 | 62 |

⁵Замын цагдаагийн албаны сайтны статистик мэдээлэл

| | | | | | | | | |
|--|-----------------------------------|---|---|---|---|---|------|------|
| | гүйцэтгэлтэйгээ уялдаж буй байдал | | | | | | | |
| ЗТХЯ болон тээврийн бусад салбаруудын үйл ажиллагааны 2017 оны үзүүлэлтүүдэд өгөх таны ерөнхий сэтгэл ханамж | | 2 | 8 | 5 | 2 | 1 | 3.58 | 71.7 |

ЗТХЯ-ны зорилго, зорилт, үйл ажиллагааны стратеги, бүтэц зохион байгуулалт нь экспертүүдийн үнэлгээний дунджаар 78 хувьтай байна. Түүнчлэн стратеги зорилтууд төсөвтэй уялдаж буй байдал, салбар байгууллагуудын албан хаагчдын харилцааны соёл, ёс зүйн байдал 72 хувь гэж тус тус үнэлсэн байна.

ЗТХЯ болон бусад тээврийн салбар байгууллагуудын албан хаагчдын цалин урамшууллын систем ажлын гүйцэтгэлтэйгээ уялдаж буй байдал 62 хувьтай гэж үнэлж байгаа тул цаашид албан хаагчдын цалин урамшууллын системийг сайжруулахад ихээхэн анхаарах шаардлагатай байна. Судалгаанд хамрагдсан экспертүүдийн талаас илүү нь салбартаа 11-ээс дээш жил ажилласан мэргэжилтнүүд байсан ба ЗТХ-ийн сайдын 2017 оны 6-р сарын 27-ны өдрийн 134-р тушаалаар батлагдсан Зам, тээврийн салбарын шагналын шинэчилсэн журам болон Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалын Дундаж цалин хөлс тогтоох журмын 3-р зүйлд заасан цалин, шагнал, урамшууллын системийн хэрэгжилт бодитоор хэрэгжиж чадахгүй байгааг харуулж байна.

ЗТХЯ болон тээврийн бусад салбаруудын үйл ажиллагааны 2017 оны үзүүлэлтүүдэд экспертүүдээс өгөх сэтгэл ханамж дунджаар 71.7 хувьтай байна. Энэ нь яам болон бусад салбаруудын үйл ажиллагаа 2017 онд тогтвортой, үйл ажиллагааны хэрэгжилт төлөвлөгөөний дагуу боломжийн сайн биелэлттэй байгааг харуулж байна. .

ЗТХЯ-ны эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлсэн байдал

Хүснэгт №24. Эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлсэн байдал. /Нийт 18 эксперт оролцсон ба мэдэхгүй гэсэн хариултыг үнэлгээнд оруулж тооцоогүй болно. /

(Маш сайн -5; сайн -4; дундаж -3; муу-2; мэдэхгүй - 0)

| № | Үзүүлэлт | Үнэлгээ | | | | | | |
|---|--|---------|---|---|---|---|--------|------|
| | | 5 | 4 | 3 | 2 | 0 | Дундаж | Хувь |
| 1 | Дамжин өнгөрөх тээврийн эрх зүйн орчныг сайжруулж, тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх | 1 | 6 | 9 | 2 | - | 3.3 | 66 |
| 2 | Олон улс, хот хооронд болон орон нутгийн чанартай авто замын төслүүдийг үргэлжлүүлэх | 1 | 7 | 6 | 2 | 2 | 3.4 | 68 |
| 3 | Бодит салбарын өсөлтийг дэмжих төмөр замын төслүүдийг хэрэгжүүлэх | 3 | 4 | 4 | 3 | 4 | 3.5 | 70 |
| 4 | “Гадаад, дотоод худалдааг хөнгөвчлөх тээвэр, логистикийн төвийн үйлчилгээг бий болгох ажлыг үргэлжлүүлэх” бодлогын хүрээнд Замын-Үүдийн логистикийн төвийн барилга, угсралтын ажлыг үргэлжлүүлэх | 5 | 4 | 2 | 5 | 2 | 3.5 | 70 |
| 5 | “Иргэний нисэхийн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх” бодлогын хүрээнд “Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежментийн концессын гэрээг байгуулах” ажил | 4 | 3 | 4 | 1 | 6 | 3.8 | 76 |
| Зам, тээврийн хөгжлийн яамны эдийн засаг нийгмийг | | 1 | 7 | 8 | 1 | 1 | 3.47 | 69.4 |

| | | | | | | | |
|---|--|--|--|--|--|--|--|
| 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн үйл ажиллагаанд өгөх таны ерөнхий сэтгэл ханамж | | | | | | | |
|---|--|--|--|--|--|--|--|

ЗТХЯ-ны эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн үйл ажиллагаанд экспертүүдийн өгөх ерөнхий сэтгэл ханамж дунджаар 69.4 хувь байна. Дамжин өнгөрөх тээврийн эрх зүйн орчныг сайжруулж, тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтэд экспертүүдийн нийлбэр дундаж үнэлгээ 66 хувьтай байгаа нь экспертүүд хууль, эрх зүйн орчинг яаралтай сайжруулах шаардлагатай байгаа гэсэн санал, хүсэлттэй шууд уялдаж байна.

Олон улс, хот хооронд болон орон нутгийн чанартай авто замын төслүүдийг үргэлжлүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ 68 хувь байгаа бол “Гадаад, дотоод худалдааг хөнгөвчлөх тээвэр, логистикийн төвийн үйлчилгээг бий болгох ажлыг үргэлжлүүлэх” бодлогын хүрээнд Замын-Үүдийн логистикийн төвийн барилга, угсралтын ажлыг үргэлжлүүлэх ажилд экспертүүд 70 хувийн үнэлгээг өгсөн. Бодлогын хувьд энэхүү ажил нь ихээхэн чухал ажил ч барилгын ажил ихээхэн удаашралтай байгаа гэж экспертүүд үзэж байсан.

Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлсэн байдал

Хүснэгт 25. МУЗГ-н 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээ: /Нийт 18 эксперт оролцсон ба мэдэхгүй гэсэн хариултыг үнэлгээнд оруулж тооцоогүй болно. /

(Маши сайн -5; сайн -4; дундаж -3; муу-2; мэдэхгүй - 0)

| № | Үзүүлэлт | Үнэлгээ | | | | | | |
|---|--|---------|---|---|---|---|--------|------|
| | | 5 | 4 | 3 | 2 | 0 | Дундаж | Хувь |
| 1 | Худалдааны гол түнш болон бусад улстай худалдааг улам хөнгөвчлөхөд чиглэсэн хэлэлцээр байгуулах чиглэлээр холбогдох судалгааг эхлүүлж, худалдааны тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулна | 3 | 2 | 5 | 5 | 3 | 3.2 | 64 |
| 2 | Тээврийн салбарын олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, бүс нутгийн дэд бүтэц, тээврийн интеграцид нэгдэн орох замаар дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлнэ | 1 | 4 | 9 | 3 | 1 | 3.1 | 62 |
| 3 | Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ | 4 | 6 | 5 | 3 | - | 3.6 | 72 |
| 4 | Эрэлтэд нийцсэн, хүрээлэн байгаа орчинд ээлтэй тээврийн ухаалаг систем нэвтрүүлнэ | 3 | 5 | 5 | 4 | 1 | 3.4 | 68 |
| 5 | Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авч, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна | 2 | 6 | 6 | 4 | - | 3.3 | 66 |
| 6 | Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу байгальд ээлтэй зогсоол, үйлчилгээний төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахыг дэмжинэ | 5 | 4 | 7 | 2 | - | 3.6 | 73 |
| 7 | Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах хүрээнд салбар бүрд батлагдан хэрэгжиж байгаа бодлогын уялдаа холбоог хангаж, боловсронгуй болгон үргэлжлүүлнэ | 3 | 2 | 6 | 3 | 4 | 3.3 | 66 |

Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2017 оны үйл ажиллагааны нийтлэг бодлогуудын хэрэгжилтийг экспертүүд дараах байдлаар үнэлж байна. Үүнд аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу байгальд ээлтэй зогсоол, үйлчилгээний төвүүдийг олон улсын стандартад нийцүүлэн байгуулахыг дэмжих ажил хамгийн өндөр үнэлгээг экспертүүдээс авсан буюу дунджаас дээш 73 хувийг авсан байна. Энэ нь энэхүү бодлогын бичиг баримтын нийтлэг үндэслэлүүдийн дотроос 2017 онд хамгийн сайн хэрэгжиж байгаа үйл ажиллагаа байна.

Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалах хүрээнд салбар бүрт батлагдан хэрэгжиж байгаа бодлогын уялдаа холбоог хангаж, боловсронгуй болгон үргэлжлүүлэх үйл ажиллагааг 66 хувь гэж экспертүүд үнэлсэн энэ нь Зам, тээврийн салбаруудын хэрэгжүүлж буй бодлогууд салбар хоорондын бодлогын уялдаа холбоог сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторийн орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжих ажлын гүйцэтгэл ЗТХЯ-ны 2017 оны тайланд 85 хувь буюу бусад нийтлэг үзүүлэлтээсээ гүйцэтгэл өндөртэй байгаа ба экспертүүдээс авсан үнэлгээ дундаас дээш нийт 72 хувь байна. Энэ нь зам тээврийн салбаруудын шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарынхан 2017 онд дэд бүтцийн хувьд эрс сайжирсныг харуулж байна.

АВТО ТЭЭВРИЙН САЛБАРТ

| № | Зорилтууд | 5 | 4 | 3 | 2 | 0 | Дундаж | Хувь |
|---|---|---|---|---|---|---|--------|------|
| 1 | Монгол Улс, ОХУ-ын стратегийн түншлэл болон Монгол Улс, БНХАУ-ын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааг гүнзгийрүүлж, худалдаа, эдийн засгийн харилцан ашигтай хамтын өргөжүүлэн хөгжүүлж, хоёр хөршийн далайн боомтыг ашиглах, тэдгээрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх зам, тээврийн таатай нөхцөлийг бүрдүүлнэ | 1 | 4 | 6 | 2 | 5 | 3.3 | 66 |
| 2 | Улаанбаатар хотын автозамын ачааллыг бууруулах, түгжрэлийг багасгах зорилгоор гүүрэн гарцуудыг шинээр байгуулан, тусгай замын автобус /BRT/-ыг нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлнэ | 3 | 7 | 3 | 2 | 3 | 3.7 | 74 |
| 3 | Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлж, дотоодын гол, мөрөн нууруудад байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын аюулгүй усан замын тээврийг хөгжүүлнэ | 3 | 3 | 2 | 5 | 5 | 3.3 | 66 |

Экспертүүдээс авсан дундаж үнэлгээ 66-74 хувьтай байна. Энэ нь тухайн салбарын хэмжээнд засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, ажлын чанар болон хэрэгжилтийн чанар дундаж үзүүлэлттэй явагдсаныг харуулж байна. Үүнээс, Далайн тээвэр, хөлөг онгоцны бүртгэлийн үйл ажиллагааг өргөжүүлж, дотоодын гол, мөрөн нууруудад байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалын аюулгүй усан замын тээврийг хөгжүүлэх ажил бусад салбаруудын үйл ажиллагааны хэрэгжилттэй харьцуулбал доогуур байна.

ТӨМӨР ЗАМЫН САЛБАРТ

| № | Зорилтууд | 5 | 4 | 3 | 2 | 0 | Дундаж | Хувь |
|---|---|---|---|---|---|---|--------|------|
| 1 | “Тавантолгой-Гашуун сухайт” чиглэлийн төмөр замаас Оюутолгойн салбар төмөр зам, “Шивээ хүрэн-Сэхэ” чиглэлийн боомтын төмөр замыг барьж дуусгана | 4 | 4 | 5 | 3 | 2 | 3.5 | 70 |
| 2 | “Тавантолгой-Гашуун сухайт”, “Хөөт-Бичигт” чиглэлийн төмөр замыг барьж ашиглалтад оруулна | 3 | 5 | 6 | 2 | 2 | 3.5 | 70 |
| 3 | “Зүүнбаян-Ханги” чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлнэ | 2 | 6 | 5 | 4 | 1 | 3.3 | 66 |

| | | | | | | | | |
|---|--|---|---|---|---|---|-----|----|
| 4 | “Эрдэнэт-Овоот” чиглэлийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ | 3 | 4 | 8 | 2 | 1 | 3.4 | 68 |
| 5 | Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлт хийж нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, “Богд Хан” төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ | 4 | 6 | 5 | 2 | 1 | 3.7 | 74 |

Төмөр замын тээврийн салбарт Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2017 онд хийгдсэн ажлын гүйцэтгэл нь тухайн үйл ажиллагааны хэрэгжилтэд экспертүүдээс өгсөн дундаж үнэлгээ 66-70 хувьтай байна. 2017 онд төмөр замын салбарт тухайн хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгдсөн үйл ажиллагаануудын хэрэгжилт дунджаас дээгүүр байгааг харуулж байна.

Улаанбаатар төмөр замын техникийн шинэчлэлт хийж нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлж, “Богд Хан” төмөр замыг барьж байгуулах ажил экспертүүдээс хамгийн өндөр үнэлгээ буюу 74 хувийн үнэлгээг авсан мөн бусад төлөвлөгдсөн үйл ажиллагаануудаасаа өндөр үнэлэгдсэн нь тухайн ажлын хэрэгжилт болон биелэлт 2017 онд сайн явагдсаныг харуулж байна.

АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАРТ

| № | Зорилгууд | 5 | 4 | 3 | 2 | 0 | Дундаж | Хувь |
|--|--|---|---|---|---|---|--------|------|
| 1 | Төрөөс агаарын тээврийн салбарт баримтлах бодлогод тулгуурлан орон нутгийн болон олон улсын нислэгийн тоог нэмэгдүүлэх, өрсөлдөөнийг дэмжих замаар тус салбарт үнэ тарифыг бууруулна | 3 | 5 | 5 | 4 | 1 | 3.4 | 68 |
| 2 | Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлж, гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн түргэн тусламжийн үйлчилгээ, иргэний агаарын тээвэр, аялал жуулчлалын чиглэлээр ашиглана | 6 | 6 | 4 | 2 | - | 3.88 | 77.6 |
| 3 | Олон улсын нисэх буудлын барилгыг өргөтгөнө | 4 | 8 | 4 | 2 | - | 3.5 | 70 |
| Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлтэнд өгөх таны ерөнхий сэтгэл ханамж | | 5 | 6 | 5 | 2 | - | 3.7 | 75 |

Агаарын тээврийн салбарт Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2017 онд хийгдсэн ажлын хэрэгжилтэд экспертүүдийн өгсөн үнэлгээ дунджаар 75 хувийн үнэлгээг өгсөн нь тухайн салбарын хүрээнд Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2017 онд сайн байсныг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Зам тээврийн хөгжлийн яамны 2017 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх хөндлөнгийн байгууллагаар "Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн" ТББ шалгарч, ажил гүйцэтгэх гэрээг Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргатай 2018 оны 03 дугаар сарын 07-ны өдөр гэрээ байгуулан 3-р сарын 9-нөөс 27-ны хооронд Улаанбаатар хот, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудад ажиллаж 874 иргэн, зам, тээврийн салбарт он удаан жил ажилласан 18 экспертүүдээс судалгаа, үнэлгээний мэдээллийг цуглуулж нэгтгэн боловсруулав.

Үнэлгээний картын аргаар үнэлгээг боловсруулсан ба үзүүлэлт тус бүрд 2-5 баллын үнэлгээг өгч 100 хувийн үнэлгээнд шилжүүлэн үнэлэв. Үйлчилгээний соёл, Үйлчилгээний ил тод шуурхай байдал, Аюул осолгүй найдвартай байдал, Үнэ тариф, Бүтээн байгуулалтын ажил зэрэг гол 5 үзүүлэлтийг 95 дэд үзүүлэлтээр, нэмэлт хандлага тодорхойлох асуултуудаар дүгнэн боловсруулав. Дүгнэлт болон зөвлөмжийг боловсруулахдаа тээврийн салбараар үйлчлүүлж буй иргэд, тээврийн салбарын ажилтан, экспертүүдийн санал хүсэлт, судалгаа үнэлгээний явцын ажиглалтын тэмдэглэл, тоон мэдээллүүдийн дүн шинжилгээнд үндэслэн боловсруулсан.

Хэрэглэгчийн үнэлгээний тайлангийн үр дүнг товч дүгнэн харуулбал:

| Гол үзүүлэлтүүд | Авто зам | Агаарын тээвэр | Төмөр зам | Улс, хот хоорондын тээвэр | Нийт дундаж оноо |
|------------------------------------|----------|----------------|-----------|---------------------------|------------------|
| Үйлчилгээний ил тод шуурхай байдал | 3.5 | 3.8 | 3.7 | 3.8 | 3.7 |
| Аюул осолгүй найдвартай байдал | 3.1 | 4.0 | 3.7 | 3.6 | 3.6 |
| Үйлчилгээний соёл | 3.6 | 4.0 | 3.6 | 3.6 | 3.7 |
| Үнэ тариф | 3.7 | 3.5 | 3.9 | 3.9 | 3.7 |
| Нийт дундаж оноо | 3.5 | 3.8 | 3.7 | 3.7 | 3.7 |
| Бүтээн байгуулалтын ажил | - | - | - | - | 4.0 |
| Нийт дундаж оноо | - | - | - | - | 3.85 |
| Нийт дундаж хувь | 70.0 | 76.0 | 74.0 | 74.0 | 77.0 |

Үнэлгээний оноог чанарын үнэлгээнд шилжүүлсэн байдал:

| Хувь | Балл | Үнэлгээ | |
|--------|------|----------|---|
| 81-100 | 5 | Маш сайн | ЗТХЯ нь хэрэглэгчийн үнэлгээ нийт дунджаар 3.85 оноо буюу 77.0 хувьтай гарсан байгаа хэрэглэгчдээс САЙН гэсэн үнэлгээг авч байна. |
| 61-80 | 4 | Сайн | |
| 41-60 | 3 | Дундаж | |
| 21-40 | 2 | Муу | |
| 0-20 | 1 | Маш муу | |

Зорчигчдын зам, тээвэртэй холбоотой МЭДЭЭЛЭЛ авч буй хэлбэрийг дүгнэж үзвэл: Иргэд ЗТХЯ-ны мэдээ, тайлан, үйл ажиллагаа, тээврийн салбартай холбоотой аливаа мэдээллийг яамны сайт болон интернетээс түлхүү авдаг бол орон нутагт зорчих аялалын мэдээллийг тасалбар борлуулалтын цэгүүдээс утсаар болон биеэр очиж тасалбар худалдан авахдаа дэлгэрэнгүй авдаг байна. Төмөр замаар зорчигчдын 58.4 хувь, Улс, хот хоорондын тээврээр зорчигчдын 43.1 хувь тус тус билетийн кассаас билет худалдан авахдаа мэдээлэл авдаг бол агаарын тээврээр зорчигчдын 49.7 хувь нь утсаар, 41.1 хувь нь веб сайт, интернетээс мэдээлэл авдаг байхад орон нутаг, хот хооронд зорчдог жолооч

нарын 37.8 хувь нь фэйсбүүк хуудаснаас мэдээлэл авдаг онцлогтой байна. Төмөр замын вокзал болон авто вокзалууд нь хөл хөдөлгөөн ихтэй орон нутгийн иргэдийн гол мэдээлэл авдаг газрууд байгаа тул тус газруудыг сайтар тохижуулж үйлчлүүлэгчдийн ая тухтай байдлыг хангаж, мэдээлэл авах дэлгэц, самбар зэргийг сайн ажиллуулах, тэмдэг тэмдэглэгээ болон аюул осолгүй байдлыг сайжруулах, иргэдэд нээлттэй тэгш хүртээмжтэй хүрч ажиллах шуурхай түргэн үйлчилгээтэй байхаас гадна ажилчдын харилцааны соёл, ёс зүй, хувцаслалт зэргийг сайтар анхаарч ажиллах, ачаалал ихтэй цэгүүдэд иргэдэд хүрч үйлчлэх угтах үйлчилгээний ажилтанг ажиллуулан хэвшүүлэх шаардлагатай байна.

Хөдөө орон нутгийн иргэдээс илүүтэйгээр олон улсын нислэгээр явж байгаа хүмүүс судалгаа үнэлгээнд илүү ач холбогдол өгч үнэн зөв бөглөж, асуудлуудад ул суурьтай хандаж байсан. Энэ нь тухайн хүмүүсийн боловсрол, мэргэжил, эрхэлж буй ажил, албан тушаал зэрэгтэй ихээхэн хамааралтай байна. Судалгаа үнэлгээний явцад ЗТХЯ-ны үйл ажиллагаа болон бүтээн байгуулалтын ажлын талаар иргэдийн мэдээлэл дутмаг байсан. Судалгааны асуумжинд дурдагдсан асуултуудаас ямар ажил хийгдэж байгаа талаар мэдэж авч байсан нь ажиглагдаж байсан. Хэдийгээр ЗТХЯ нь өөрийн сайт болон харьяа байгууллагуудын сайт, фэсбүүк хуудас бусад мэдээллийн сувгуудаар тайлан мэдээгээ байршуулан цацаж, байгаа боловч иргэдийн дийлэнх нь тэр бүр сонирхож мэдээлэл авдаггүй байна. ЗТХЯ нь иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэх сурталчилгаа, мэдээ түгээлтийн үр дүнтэй арга хэлбэрийг сонгож мэдээллийг хүртээмжтэй түгээх хэрэгтэй байгаагаас гадна сурталчилгаа, ухуулга нөлөөллийн шаардлагатай санхүүжилтийг 2018, 2019 оны ЗТХЯ-ны төсөвт суулгаж өгөх нь зүйтэй юм.

ЗТХЯ нь менежментийн шинэчлэлийн хувьд төмөр зам, агаарын тээврийн салбарт илүүтэй анхаарч ажиллаж байгаа дүр зураг нийтлэг ажиглагдаж байна. ЗТХЯ нь бодлого шинэчлэлтийг яаралтай хийж хууль эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна. Ялангуяа орон нутгийн авто тээврийн төвүүдийн менежмент, үйл ажиллагааг хөгжүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна. 2017 онд Монгол улсын гадаадын нислэгээр 1.3 сая, дотоодын нислэгээр 250 мянган хүн зорчсон байна. Агаарын тээврийн салбарт хийгдсэн хамгийн том бүтээн байгуулалтын ажлыг судалгаанд оролцогчид Хөшигтийн хөндийн олон улсын онгоцны буудал гэж үнэлсэн. Хөшигтийн хөндийн олон улсын онгоцны буудал нь одоогийн Чингис Хаан олон улсын нисэх онгоцны буудлаас 2 дахин хүчин чадавхи том буудал болж байгаа. Иймд Монгол улс агаарын тээврээ чөлөөлбөл олон компани нисч, зорчигчийн тоо ихсэх тусам өрсөлдөөн ширүүсч, хэрэглэгчийн өндөр үнэтэй гэж буй нислэгийн тийз хямдарч, аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хувьсгал гарах юм. Энэ өрсөлдөөн эхэлмэгц, үйл ажиллагааны зардлын гуравны нэгийг эзэлдэг түлшний монополь ч задрах боломжтой юм.

ЗТХЯ нь тээвэр логистикийн бодлого үйл ажиллагааг төлөвлөхдөө "Улаанбаатар төмөр зам" ХНН-н бодлого саналыг илүүтэй тусгахаас гадна төмөр замаар тээвэрлэлт хийдэг, худалдаа эрхэлж буй аж ахуй нэгж байгууллагуудын саналыг сонсч, тэдний саналыг тусгаж байх нь чухал байна. Жишээлбэл төмөр замын тээвэрлэлтийн үнэ тариф байнга хэлбэлздэг тогтвортой байдаггүй, жил бүр нэмэгдэж байдаг. Бусад улс оронд тээврийн компаниуд нэгдэж тээвэрлэлтийн зардлууд буурч байгаа жишиг байгаа тул

энэхүү асуудалд эрх зүйн тодорхой зохицуулалт хэрэгтэй байна. Логистикийг зөвхөн төмөр замаар биш агаараар, авто тээврээр давхар хөгжүүлэх, түүнчлэн логистикийн агаараар болон авто тээврийн бодлогыг, тээвэр зуучид чиглэсэн бодлогуудыг хөгжүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн авто тээврийн төвүүд нь замын эвдрэлийг чухалчилж даац хэтрэх асуудал их гардаг бөгөөд том машины жинг үнэлдэг болох, хяналтын цэгүүдэд пүүтэй болох зэрэг санал гарч байснаас гадна замын эвдрэлийг удаан засдаг, эвдрэлийг машинууд тойрч гарах гэж яваад аюул осол аваар их гардаг тул замын эвдрэл гэмтлийг шуурхай чанартай хийдэг болох талаар, орон нутгийн авто тээврийн төвүүдэд тодорхой хэмжээнд эрх мэдэл олгох, одоогоор бүх шийдвэр гаргалт авто тээврийн үндэсний төв дээр төвлөрдөг талаар санал хүсэлтээ илэрхийлж байсан.

ЗӨВЛӨМЖ

ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ-нд:

- ✚ Хууль эрх зүйн бичиг баримтуудыг шинэчлэн сайжруулж, дагаж гарах журмуудыг сайн боловсруулах шаардлагатай. Журмын боловсруулалтыг хийхдээ хэрэглэгч нарт тулгамдаж буй гол асуудлыг судалж, тэдний саналыг сонсч нээлттэй сонсгол хийх шаардлагатай.
- ✚ Нисэх онгоцны буудал, Төмөр замын вокзал болон авто вокзалууд нь иргэдийн урсгал ихтэй газрууд байгаа тул тохижилт сайн хийж, электрон том дэлгэц, мэдээллийн самбар ажиллуулах, Яам болон харьяа байгууллагуудын улирал бүрийн тайлан мэдээг хэвлэмэл материалаар байршуулж иргэдэд хүргэх.
- ✚ Иргэд жолооч нарт зориулсан тэдгээрийн хамгийн их хэрэглэж мэдээлэл авч буй сувгийг соргоогоор мэдээрч, замын бүтээн байгуулалт, хот хоорондын аялалын маршрут, цагийн хуваарь, үнэ тариф, хөнгөлөлт урамшуулал, салбарын яамны үйл ажиллагаа, бодлого журмын хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч байдаг фэйсбүүк группийг нээн тогтмол ажиллуулж байх шаардлагатай байна. Энэ нь мэдээллийг өргөн хүрээнд түгээх хамгийн хямд зардалтай амьд харилцаа үйлчилгээний нэг хэлбэр болоод байна. Жолооч нарын 37.8 хувь нь фэйсбүүх идэвхтэй хэрэглэгчид байна.
- ✚ Фэйсбүүк группийн мэдээллийг бэлтгэхдээ сонирхолтой бэлтгэх, товч текст мэдээлэлтэй байх, өнгө үзэмжтэй зургийн сонголт хийх, иргэдийг уриалах идэвхжүүлэх мессежийг байнга өгдөг байх шаардлагатай.

АГААРЫН ТЭЭВРИЙН САЛБАРТ:

- ✚ Нисэх буудлын тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээ сайн байгаа ч хогийн сав байршуулалт харьцангуй цөөн байна. Хогийн савны тоог тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх шаардлагатай байгаа бөгөөд хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн ангилан ялгалт хийх боломж бүхий хогийн савнуудыг байршуулах шаардлага байна. Хүн их цуглардаг газруудад хогийн савыг хангалттай тоогоор байршуулах нь орчны бохирдолыг бууруулахаас гадна иргэдэд ээлтэй орчинг үүсгэдэг. Орон нутгийн нислэг хүлээж буй иргэд явахдаа хүлээлгийн танхимын сандал дээр хогоо шууд хаяж явдаг зуршил, хандлага, бүдүүлэг соёлгүй зан гаргаж байгаа байдал нэлээдгүй ажиглагдсан. Иймд хүлээлгийн танхимд иргэдэд зориулсан санамжууд байршуулах нөлөөллийн ажлууд хийх хэрэгтэй байна.
- ✚ Орон нутгийн нислэгийн билет өндөр үнэтэй байдаг гэтэл ойрхон нисэхээр хоол өгдөггүй бөгөөд жигнэмэг өгдөг байна. Мөн холын нислэгт аялах явцад өгдөг хоол хүнсэнд ч иргэдийн дийлэнх нь сэтгэл дундуур байдгаа илэрхийлж байсан. Иймд нислэгийн хоол хүнсийг сайжруулахад анхаарах шаардлагатай байна.
- ✚ Мэдээллийн ажилтан ажлын байрандаа тогтмол байдаггүй бөгөөд нислэгтэй үед гарч ирдэг, мэдээлэл авах хүсэлтэй иргэдэд хаана хэнд хандах гээд төвөгтэй байдал үүсч байсан. Иймд мэдээллийн ажилтанг тогтмол ажлын байранд нь ажиллуулахад анхаарах
- ✚ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй үйлчилгээ дутмаг урсдаг шат байхгүй, лифт нь зөвхөн 4 давхарт зогсдог оффисын ажилтнуудад зориулсан, 2,3-р давхарт

хөгжлийн бэрхшээлтэй тэргэнцэртэй иргэн гарч чадахгүй байна. Тэргэнцэртэй хүнд явах чиглүүлэх тэмдэг тэмдэглэгээ байхгүй байна. Иймд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн ээлтэй орчин бүрдүүлж ажиллахад анхаарах.

- ✚ Нисэх буудалд хүнс худалдаалдаг цэгүүд тогтсон жишиг үнэтэй биш, нэг барааг үнийн хэлбэлзэлтэй янз бүр худалдаалж байна. Түүнчлэн иргэдийн гар тээш түр хадгалах цэг орчин нөхцөлийг бүрдүүлээгүй, Хүүхдийн орчин байхгүй, Амралтын орчин байхгүй зэрэг иргэдийн тав тухыг хангасан үйлчилгээний соёл дутмаг байгаа тул орчин үеийн иргэдийн хэрэгцээ шаардлагыг мэдэрч тохижилт үйлчилгээг анхаарах шаардлагатай байна.
- ✚ Зорчигчдод зориулсан гар тээш болон ачаа тээшинд юу авч явах боломжтой, юуг хориглосон талаарх мэдээлэлийн самбар орон нутгийн нислэгт байхгүй байгаа нь иргэдийг ихэд бухимдуулж байна. Мэдээллийн санамж мэдээллийг сайжруулах шаардлагатай.
- ✚ Нисэх буудлын үүдээр орох хэсэг нь плита учир өвөл иргэд яарч орж ирэхэд халтирч унах асуудал нэлээдгүй байдаг байна. Халтиргаа гулгаанаас сэргийлсэн арга хэмжээг өвлийн цагт авч байх, аюулгүй байдлыг сайжруулах.
- ✚ Иргэд агаарын тээврийн компаниудыг ачаа авах жинг хэтэрхий бага гэж шүүмжилж байгаагаас гадна ачааны бүрэн бүтэн байдал найдвартай биш хагарч гэмтдэг гэж үнэлж байна. Иймд орон нутагт ачаа тээвэрлэлтийн үйлчилгээг чанаржуулах.
- ✚ Хөдөө орон нутгийн иргэдэд нисэх буудал явах нийтийн тээврийн мэдээлэл байхгүй хомс байдаг байна. Хаанаас ямар чиглэлийн хэдэн номерийн нийтийн тээвэр үйлчлэх талаар мэдээлэл байдаггүй өндөр үнэтэй такси хөлсөлж явдаг талаар шүүмжлэлтэй хандаж байна. Иргэдэд ямар нийтийн тээврийн хэрэгсэл ямар маршрутаар, ямар цагийн хуваариар зорчиж буй талаар мэдээллийг нисэх буудал дээр сайн өгдөг байх.
- ✚ Нисэх буудлын мэдээллийн дэлгэц их жижиг хараа муутай хүнд харагдац маш бага боломжгүй байна. Мэдээллийн дэлгэцийг томруулах олон улсын жишигт хүргэх.

ТӨМӨР ЗАМЫН САЛБАРТ:

- ✚ Орон нутгийн төмөр замын өртөөнүүдийн үйл ажиллагааг сайжруулан анхаарах шаардлагатай байна. Жижиг өртөөнүүдийн одоо ажиллаж буй цагийн хуваарьт дүн шинжилгээ хийж иргэдэд үйлчлэх, ээлтэй орчин бүрдүүлж ажиллах талаас анхаарах. Иргэд дараагийн дамжих суудлаа хүлээн орой, шөнийн цагаар өртөөний байранд хүлээх боломж байдаггүй өртөөний ажилчид иргэдийг хөөж гаргадаг, суудал ирэх үеэр өртөө онгойж ажилладаг бусад үед иргэд гадаа дараагийн суудлыг хүлээдэг нь өвлийн улиралд ихээхэн тав тухгүй байна. Тухайлбал: шөнийн 02:30 цагт галт тэрэг явах бол өртөө нь 02:00 цагт онгойж билет бичдэг. Энэ нь ажиллах цагийн хуваарь тохиромжгүй байна. Түүнчлэн 23 цагт тухайн өртөөнд бууж дараагийн галт тэргийг хүлээж байгаа хүнд 02:00 цаг хүртэл гадаа хүлээх шаардлага гарч байна.
- ✚ Төмөр замаар зорчих тасалбар борлуулалтын менежмент үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. Галт тэрэгний тасалбар борлуулалтын ухаалаг програмчлал, дэлгэц төхөөрөмжийг нэвтрүүлэн ашиглаж эхлэхийг иргэд ихээр хүсч байна. Энэхүү ухаалаг тасалбар борлуулалтын үйлчилгээ нь кино театрын тасалбар борлуулалтад өргөнөөр ашиглагдаж байна. Борлуулагч болон үйлчлүүлэгч нарт 2

талдаа зэрэг харагддаг дэлгэц нь сул чөлөөтэй суудал хаана байгааг харагдуулахаас гадна үйлчлүүлэгч хаана суухаа өөрөө шийдэж захиалгаа өгдөг. Билетийн касс карт уншдаггүй зөвхөн бэлэн мөнгөөр гүйлгээ хийдэг. АТМ байдаг ч бүх банкных байдаггүй тул иргэд бэлэн мөнгө авахдаа 500 төгрөгний шимтгэл төлдөг нь иргэдийн дургүйцлийг хүргэдэг байна. Түүнчлэн билетийн кассын ажилчид галт тэрэгний нийтийн зорчих хэсгийн доогуурх суудлыг, зарагдсан гэж муу суудлыг түрүүлж зарж доогуурх суудлыг үнэ нэмж зардаг хувийн билетийн хэсэгрүү шилжүүлэх хандлага их байдаг байна. Нийтийн зорчих хэсгийн 3 давхарт билет бичдэг энэ нь иргэдэд сууж явах суудлын хүрэлцээг ихээхэн хязгаарлаж суух боломжгүй болгодог байна. Тасалбар борлуулагч иргэдэд тасалбар борлуулахдаа суудлын вагон гэж тайлбарлахгүй зарж байгаагаас маргаан хэрүүл их гардаг байна. Замын үүд чиглэлд суудлын хүрэлцээ байнга муу байдаг байна. Билетийн түгээлтийн мэдээлэл муу иргэд тасалбар хаанаас авахаа сайн мэддэггүй байна.

- ✚ Замын Үүдийн вокзал нь дотоод гадаадын иргэд их үйлчлүүлдэг хөл хөдөлгөөн ихтэй ч иргэд мөнгөө төлөөд түр амрах цагийн өрөө байдаггүй учир дутагдалтай байна. Иргэдийг амрах орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.
- ✚ Галт тэргэнд парк шинэчлэлт сайн хийдэггүй, агаар цэвэршүүлэгч болон агааржуулагч байхгүй, өвлийн цагт галт тэрэг галлагаа хийхээр галт тэрэг тэр чигээрээ тоосонцор болдог нь төмөр замын үйлчилгээний ажилчид болон зорчигч нарын эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй юм. Агааржуулалтын системийг сайжруулах шаардлагатай байна.
- ✚ Галт тэрэг дотор хаягжуулалт, тэмдэглэгээ муу хэддүгээр вагон нь мэдэгдэхгүй, иргэдэд зориулсан аюулгүйн зааварчилгаа дутмаг, галын хор, анхны тусламжийн хайрцаг хаана байгаа нь мэдэгддэггүй. Галт тэрэгний үйлчлэгчийн харилцааны соёл муу байна гэж зорчигчид нэлээдгүй шүүмжилж байна. Галт тэрэгний үйлчилгээний соёл, менежментийг сайжруулах, иргэнд ээлтэй аюулгүй байдлыг бүрдүүлсэн зааварчилгаа мэдээллүүдийг ил байршуулах. Галт тэргээр зорчигчдод зориулсан дараагийн зогсоолыг цаг минуттай зарладаг үйлчилгээг нэвтрүүлэх.

АВТО ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ: /Улс, хот хоорондын тээвэр/

- ✚ Орон нутагруу тээврийн үйлчилгээ үзүүлж буй эрх бүхий байгууллагын автобуснууд нь харилцан адилгүй байна. Зарим автобуснууд тохитой цэвэрхэн, аюулгүй ажиллагааг сайн хангасан, заавар санамж бүрэн, жолоочийн хувцаслалт, харилцааны соёл сайхан байхад тохижилт цэвэрлэгээ муу, тух муу, жолооч нь харилцааны соёлгүй бүдүүлэг зан ааштай автобуснууд байна. Ихэвчлэн орон нутгийн дугаартай автобусанд сөрөг нөхцөл байдал ажиглагдаж байсан. Жолооч нарт мэдээллийг албан сургалтаар болон бичгэн хэлбэрээр өгөх нь илүү үр дүнтэй байна. Орон нутгийн жолооч, хотын жолооч нарыг жигд соёлтой болгон хөгжүүлэх
- ✚ Орон нутагт явж буй автобус нь зорчигч цөөн хэдий ч дайвар ачаа их авч явдаг, ачааны үнэлгээ баруун болон зүүн авто вокзалд өөр өөр жишиг үнэлгээтэй байна. Нэг дайвар ачааны дундаж үнэлгээ 5000 төгрөг байна. Тухайн ачааг жолоочийн үзэмжээр шийдэж үнэлгээг тогтоож байна. Энэ нь бүртгэлийн систем байхгүй, ачаа тээвэрлэлтийн журам мөрдөгдөхгүй байгаатай шууд холбоотой байна. Хүний ачааг хиллэхгүй баримжаагаар үнийг нь авдаг. Энэ нь алсын замд даац хэтрүүлэх осол

аваар гаргах эрсдэлийг нэмэгдүүлж байна. Ачаа тээвэрлэлт бүртгэлийн менежмент системийг сайжруулах шаардлагатай байна.

- ✚ Судалгаа үнэлгээний явцад авто вокзалаас зорчих тасалбар авахгүй бэлэн мөнгө жолоочид өгч зорчиж буй тохиолдлууд хэд хэд гарч байсан. Энэ нь авто тээврийн хяналтын тогтолцоо сул байгааг харуулж байна. Хяналтын тогтолцоог хөгжүүлэн сайжруулах арга хэмжээг авах
- ✚ Авто тээврийн үйлчилгээ эрхэлж буй эрх бүхий байгууллагуудын автобусанд иргэд цөөхөн суудаг гол шалтгаан нь хулгайн зөвшөөрөлгүй тээвэр их байдагтай шууд хамаатай байна. Хулгайн тээвэр нь хурдан, богино хугацаанд явдаг гэсэн үзүүлэлтээр иргэд хулгайн тээврийг илүү сонгон үйлчлүүлж байна. Хулгайн тээврийг хязгаарлах талаар дорвитой шийдэл, арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.
- ✚ Хот хооронд замын гэрэлтүүлэг байхгүй, машинууд гэрлээ шилжүүлдэггүй, хажуугаар машинууд гүйцэж хурд ихтэй явдаг, Замын гуанзны хоол болон ариун цэврийн байгууламж муу байдаг авто тээврийн хөгжлийн үндэсний төв энэ асуудалд анхаарч, дорвитой арга хэмжээ авахгүй байна гэж зорчигчид ихээхэн шүүмжилж байсан. Иймд Япон авто машинуудын гэрлийн ойлтыг өөрчлөх арга хэмжээг үндэсний хэмжээнд эрчимжүүлэх, зам дагуух хоолны газар, ариун цэврийн байгууламжийн үйлчилгээг сайжруулахад анхаарах.
- ✚ Зам тээврийн эрхтэй автобусны жолооч нэг өдөрт 400км-ээс дээш хурдтай явж болохгүй гэсэн хуулийн заалттай тул Улаанбаатараас Өмнөговь аймаг явахад заавал смен жолооч цалинжуулж авч явдаг энэ нь алдагдал ихтэй байдаг, зам нөхцөл байдал сайжирсан үед дундаж хурд 80 км/цаг байх нь тохиромжгүй байгаа бөгөөд дундаж хурд 100-120 км/цаг байх хэрэгтэй байна гэж жолооч нар саналаа илэрхийлж байна. Түүнчлэн малчдад хандаж мэдээлэл сайн өгөх шаардлагатай байгаа бөгөөд гэнэт энд тэндээс зам дээр мал гарч ирэн аваар осол гаргах эрсдэлийг нэмэгдүүлж байгаа тул малчдад чиглэсэн ухуулга нөлөөллийн ажлыг сайжруулах болон мал бүхий хэсэгт анхааруулах тэмдэг тэмдэглэгээг сайжруулах

ИРГЭД БОЛОН ЭКСПЕРТҮҮДИЙН САНАЛ, ХҮСЭЛТ

Агаарын тээврийн салбарт:

- ✚ Нислэгийн тийз ний үнийг бууруулах
- ✚ Аймаг бүрийг агаарын тээврээр холбох
- ✚ Аюулгүй найдвартай байдлыг нэмэгдүүлэх
- ✚ Хүлээлгийн танхимын тав тухыг нэмэгдүүлэн цэвэр ус, тээш хадгалах хэсэг, интернет, хүүхэд саатуулах хэсэг зэргийг шийдвэрлэн олон улсын үйлчилгээнд ойртуулах
- ✚ Мэдээлэл хүргэх сувгаа нэмэгдүүлэн, хүртээмжийг сайжруулах
- ✚ Онгоцны буудлын авто зогсоолыг тодорхой хугацаанд үнэгүй болгох
- ✚ Хаанаас, юуг лавлаж болох талаар мэдээлэл өгдөг байх
- ✚ Шинэ техник, технологи нэвтрүүлэх
- ✚ ЗТХЯ-ны мэргэжилтнүүд асуудлын дотогшоо сайн орж ажиллах, дарга нарын хүрээнд шийдэх биш, яриад өнгөрдөг биш асуудлуудыг харж, доголдолтой асуудлуудыг шуурхай шийддэг байх юм бол яамны зорилтууд биелэгдэх бүрэн боломжтой.

- ✚ ЗТХЯ-ны бодлого үйл ажиллагааг сайжруулахад гол анхаарах асуудал бол хүний нөөцийг чадваржуулан бэхжүүлэх асуудал байна. Ихэнх албан хаагчид залуучууд байгаа. Залуучуудыг ажлын байран дээр нь маш сайн дадлагажуулж мэргэшүүлэх, мэдлэг ур чадварыг үнэлж чаддаг байх шаардлагатай байна. Мэргэжилтнүүд шинийг эрэлхийлдэг санаачлагатай байж үр өгөөжтэй бичиг баримтуудыг боловсруулдаг байх шаардлагатай байна.
- ✚ 2016-2020 онуудад Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг боловсруулагдан гарч ЗТХЯ-ны бүхий л салбар байгууллагууд дунд хэрэгжиж байгаа. Иргэний нисэхийн байгууллагуудад Эдийн засаг бодлого, зохицуулалтын хэлтэс байгаа хэдий ч манай авиа компаниуд ашигтай ажиллаж чадахгүй байна. Хэдхэн компаниуд ажиллаж байгаа өнөө маргаашаа харж, үйл ажиллагаагаа явуулж байгаа гэж хэлж болохоор байна. Төрөөс баримтлах бодлогын баримт бичигт аваад хэрэгжүүлж болохоор авиа компаниудаа дэмжсэн эдийн засгийн зөв бодлого, зохицуулалт тусгагдаж өгөөгүй байна.
- ✚ Ажлын ачаалал ихтэй /хортой нөхцөлд ажилладаг/ иргэний нисэхийн салбарын багц дүрмүүдийн шинэчлэл удаан хийгдэж байна.
- ✚ Мэргэжлийн байгууллагад улс төрийн томилгоо хийх нь салбарт тулгардаг хамгийн их хүндрэл бэрхшээл байна.
- ✚ Инновацийг нэмэгдүүлж, техник технологи шинэчлэл, хөрөнгө оруулалтыг дэмжих
- ✚ Мерит тогтолцоогоор ажилчдын мэдлэг чадварыг зөв үнэлэх хэрэгтэй

Төмөр замын салбарт:

- ✚ Агааржуулалтын системийг сайжруулах
- ✚ Ариун цэврийн өрөөний ариутгал, цэвэрлэгээг сайжруулах
- ✚ Интернетийн хурдыг нэмэгдүүлэх
- ✚ Баярын үеийн ачааны болон суудлын вагоны ачааллыг зохицуулах
- ✚ Хүлээлгийн танхимын орчин нөхцөлийн сайжруулах
- ✚ Билет худалдан авах системийг хялбаршуулах /Өөртөө үйлчлэн билет авах машин г.м/
- ✚ Замын-Үүдээс-Улаанбаатар чиглэлийн ирэх вагоны цагийг хойшлуулах 20 цаг болгох
- ✚ Үйлчилгээний ажилтнуудын харилцаа, хандлагыг сайжруулах
- ✚ Суудлын 3-р давхрыг местэнд бичихгүй байх
- ✚ Төмөр замын хувьд сүүлийн 2 жилд улсын эдийн засгийн өсөлтөд ихээхэн хувь нэмэр үр өгөөжтэй ажилласан. Иргэний нисэхийн агаарын тээврийн навигацын орлого жилээс жилд өсч байгаа. Автотээвэр айхтар сайжирч шинэчлэгдэхгүй байгаа.
- ✚ Зорчигчийн вагонуудыг, паркийг шинэчлэх / маш олон жил болсон/
- ✚ Техникийн гэмтлээс болон буруутай үйл явдал энгийн ажилчид руу илүү чиглэж, арга хэмжээ авагддаг

Авто зам, тээврийн салбарт /Улс, хот хоорондын тээвэр/

- ✚ Орчин үеийн техник, технологид нийцсэн, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн дүрэм журам бодлого хэрэгтэй байна.
- ✚ Баруун зүүнийг холбосон төмөр замтай болох хэрэгцээ их байна. Уул уурхайн үйл ажиллагаа ихтэйгээс замын эвдрэл их байна.
- ✚ Замын постуудыг сөайжруулан жолооч нарыг карттай болгох, зорчиж буй машин картаа уншуулан алсын замд гардаг байх. Замын постоор тасалбар өгдөг үе

хоцрогдсон, Зам ашиглалтын татвар аваад байгаа хирнээ юунд зарцуулагддаг нь мэдэгддэггүй, мэдээлэл байхгүй байна гэж иргэд үзэж байна.

- ✚ Дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлбэл зүгээр байна. Ийм тээвэр орон нутагт их байна. Тэд нараас татвар авах хэрэгтэй байна. Үүнийг хянадаг тогтолцоо байхгүй, эрх зүйн зохицуулалт хийж өгвөл зүгээр байна.
- ✚ 21 аймгийг холбосон авто замын сүлжээтэй болох хэрэгтэй байна. Аймгуудын хооронд холбосон замтай байх. Аймаг хооронд явдаг нийтийн тээвэртэй болох. Мөн сум хооронд нийтийн тээвэртэй болмоор байна.
- ✚ Орон нутагт шөнө очиход хүндрэлтэй тул УБ-с хөдлөх цагийг зөв зохион байгуулах
- ✚ Хүлээлгийн танхимын суудал, хүрэлцээ, тав тухыг сайжруулан ажиллах хугацааг уртасгах
- ✚ Жолооч, үйлчилгээний ажилчдын харилцаа, биеэ авч явах байдлыг сайжруулах
- ✚ Иргэдийг соёлтой үйлчлүүлж сургах нөлөөллийн ажлуудыг тогтмол зохион байгуулж байх
- ✚ Интернетээр билет захиалга хийхэд гарч буй хүндрэлүүдийг багасгах
- ✚ Холын аймгуудад унтлагын автобус явуулах
- ✚ Замын-Үүд суманд олон улсын авто вокзал байгуулах
- ✚ Зорчигч тээврийн асуудлыг иргэдэд ойр, хөдөө орон нутгийг дэмжих бодлого хэрэгтэй байна
- ✚ Орон нутгийн авто тээврийн төвүүд нь аж ахуйн тооцоот газрууд байдаг тэр чиглэлээр нь хөгжих боломжийг олгож өгөх хэрэгтэй байна. Хөгжих боломжуудыг их хязгаарлаж байна.
- ✚ Олон улсын стандартыг үйлчилгээнд нэвтрүүлэх нь /чанарын тогтолцоо нэвтрүүлэх/ чухал байна.
- ✚ ГХТ Хяналтын үзлэг явуулах талбайг, тоног төхөөрөмжийг хөдөө сумдад байгуулах хөрөнгийг шийдвэрлэх өгөх нь чухал байна.

ХАВСРАЛТ



“ЭРҮҮЛ МЭНД НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭЛЭН” ТББ

14210, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Элчингийн гудамж, Милгаун, 504

Утас/Факс: 976-70002444

E-сэйл: contact@hspim.mn

Вэб сайт: www.hspim.mn

2018.03.12 № 01/13
Тангил -ны №

ЗАМЫН-ҮҮД ДЭХ ГААЛИЙН
ГАЗРЫН ДАРГА Д.ЗОРИГОО
ТАНАА

Хүсэлт гаргах нь

Зам тээврийн хөгжлийн яамны 2017 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх хөндлөнгийн байгууллагаар Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн шалгарч, ажил гүйцэтгэх гэрээг Зам тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргатай 2018 оны 03 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан билээ.

Энэхүү хэрэглэгчийн үнэлгээнд иргэд болон мэргэжлийн байгууллагын ажилтан, албан хаагчид хамрагдаж байгаа тул танай байгууллагын холбогдох ажилтнуудыг судалгаа, үнэлгээнд хамруулж өгнө үү


Хүндэтгэсэн:

Тэргүүн  А.Нямдорж



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ

ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ- 2017




СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ



Нийт судалгаа үнэлгээнд оролцогчдын тоо- 874

Боловсролын төвшин





Судалгаанд оролцогчдын салбарын төлөөлөл



2017 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ӨГСӨН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Үзүүлэлт тус бүрт 2-5 баллын үнэлгээг өгч дүгнэв. Доорх 5-н гол үзүүлэлтийг нийт 96 дэд үзүүлэлтээр дүгнэсэн болно.



4.0

2017 ОНД ХИЙСЭН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛД ӨГСӨН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ /НИЙТ СУДАЛГААНД ХАМРАГДСАН ХЭРЭГЛЭГЧДИЙН ДУНДАЖ ОНОО/

- Олон улсын шинэ нисэх онгоцны буудал-УБ чиглэлийн 32 км хурдны авто зам барих ажил (Гүйцэтгэл- 54.2%)
- УБТЗ-н галт тэрэгний хөдөлгөөнийг зохицуулах автомат хориглолын систем, диспетчерийн төвлөрүүлэлт нэвтрүүлэх ажил (Гүйцэтгэл- 70%)
- УБТЗ-н 200 км гол замын их засварын ажлын хүрээнд 50 км замд их засвар хийж гүйцэтгэсэн Замын-Үүдэд тээвэр логикийн төв байгуулах ажил (Барилгын ажлын гүйцэтгэл- 81%)
- Аюулгүй найдвартай, их багтаамжийн нийтийн тээврийг хөгжүүлэх парк шинэчлэлийн ажлын 2017 онд 100 автобус авах зорилтын хүрээнд 43 орон нутгийн тээврийн автобус авсан (Гүйцэтгэл- 70%)
- Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замд өргөтгөл, шинэчлэлийн ажил (Гүйцэтгэл- 40%)
- Туул гол дээгүүрх Баянзүрхийн 288метр урт болон Сонсголгогийн 289.4метр урт төмөр бетон гүүр (Гүйцэтгэл- 70%)
- Авто замын арчлалт, засварын ажлыг норм, нормативын дагуу хийж гүйцэтгэсэн
- УБ-Дархан-Алтанбулаг, УБ-Арвайхээр, Дархан-Эрдэнэт, УБ-Чингис, Налайх-Чингис чиглэлийн нийт 504 км авто замд их засвар шинэчлэлийн ажил (Гүйцэтгэл- 65%)
- Нийслэл болон аймгийн төвд улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээний авто буудал барих ажил (Гүйцэтгэл- 90%)

976-62263179
(976-11)-312315

И-мэйл: info@mrtd.gov.mn

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингисийн өргөн чөлөө-11 Засгийн газрын 13 дугаар байр